УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХОРШООНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: **СТ-23/210**
2023.10.03

Хянасан:	Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн Захирал Ц.Цогзолмаа
Хянасан:	Зөвлөх Д.Халиун
Судлаачид:	ЭШАА О.Билгүүтэй; Референт Р.Оргилмаа; Референт Р.Нургүл; ЭША С.Золжаргал; ЭША Б.Баянмөнх.

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

АГУУЛГА

УДИРТГАЛ.....2
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ.....3
СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ.....5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.....5
ХОРШООНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ.....5
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТУУД.....7
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА.....9
БНСУ.....9
ЯПОН УЛС.....14
БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС.....20
НОРВЕГИЙН ХААНТ УЛС.....25
ХБНГУ.....31
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ.....34

УДИРТГАЛ

“Хөдөө аж ахуйн салбарын хоршооны эрх зүйн орчин, гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Хөдөө аж ахуйн салбар өндөр хөгжсөн орнуудын хоршооллын зарчим, үйл ажиллагаа, менежмент, эрх зүйн орчны туршлагыг судлах.

Хамрах хүрээ:

Судалгааны нэгдүгээр бүлэгт: Хөдөө аж ахуйн салбарын хоршооны тухай ойлголт, олон улсын чиг хандлага, хоршооны үндсэн зарчим;

Хоёрдугаар бүлэгт: Судалгаанд дурдсан орнууд болох БНСУ, Япон, БНКазУ, ХБНГУ болон Норвегийн Хаант Улсын хөдөө аж ахуйн салбараа хоршооны зарчмаар хөгжүүлсэн түүх, тэдгээрийн үүсэл хөгжил, онцлог, хөдөө аж ахуйн хоршоодын эрх зүйн орчин, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэгдсэн борлуулалт, хангамжийн схем, тогтолцоо, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн талаар судаллаа.

Судалгааны бүтэц:

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

- Хоршооны тухай ойлголт
- Хоршооны олон улсын чиг хандлага

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БУСАД ОРНЫ ТУРШЛАГА (БНСУ, ЯПОН, БНКазУ, ХБНГУ, НОРВЕГИЙН ХААНТ УЛС)

- Хөдөө аж ахуйн хоршооны туршлага, ерөнхий мэдээлэл
- Хөдөө аж ахуйн хоршооны эрх зүйн орчин
- Хөдөө аж ахуйн хоршооны борлуулалт, хангамж

Түлхүүр үг: *Хөдөө аж ахуй, Хөдөө аж ахуйн хоршоо, Хоршооллын хөгжил*

Key words: *Agriculture, Agricultural Cooperatives, Cooperative development*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Олон улсын хоршооллын холбооноос гаргасан мэдээгээр дэлхий дахинд хоршоод нь хүн төрөлхтний 12% -иас илүү нь дэлхийн 3 сая хоршооны аль нэгэнд багтдаг гэсэн тоо мэдээлэл гарсан байна.[1] Японд 3 гэр бүл тутмын нэг нь хоршооны гишүүн, хөдөө аж ахуй /ХАА/-н хоршоо нь 10 сая гаруй гишүүнтэй буюу хүн амын 8%, ХБНГУ-д 4 хүн тутмын нэг буюу 22 сая гаруй хүн хоршооны гишүүн, үүнээс ХАА-н хоршоод 1,4 сая гишүүнтэй, Норвеги Улсын нийт хүн амын талаас илүү нь буюу 2.8 сая гаруй нь хоршооны гишүүн[2], үүнээс ХАА-н хоршоод 40.000 гаруй гишүүнтэй бөгөөд ойролцоогоор 75 тэрбум Норвеги кроны хөрөнгийн эргэлттэй байна.[3]

БНСУ-ын ХАА-н хоршоод нь 2 сая гаруй гишүүнтэй буюу хүн амын 4% хувьтай тус тус тэнцүү байгаа бол манай улсад ХАА-н хоршоод 100 мянга гаруй гишүүнтэй байгаа нь хүн амын 3,3 хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын хувьд 2013 онд ХАА-н хоршоологчдын бүсийн зөвлөгөөний үеэр хоршоодын төлөөллүүдийн дунд явуулсан судалгаа, 2014 онд ХАА-н маркетинг төслийн хүрээнд Баруун болон Хангайн зарим аймагт явуулсан судалгааны дүнгээр орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нийт хоршоодын 70 орчим хувь буюу 1508 нь ХАА-н хоршоо байна. Хоршоод ихэвчлэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл, ханган борлуулалт, түүхий эд бэлтгэл, мал эмнэлэг үржлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 48.5% нь 9 гишүүнтэй байна.

ХАА-н хоршоодтой холбоотой харилцааг, ХБНГУ, Норвеги улс нь хоршооны хуулиар зохицуулж байгаа бол БНСУ болон Японд хоршоологчдын томоохон салбар тус бүр бие даасан хуультай байх бөгөөд ХАА-н салбарыг Хөдөө аж ахуйн хоршооны тухай хуулиар зохицуулж байна. БНКазУ-ын хувьд хөдөө аж ахуйн хоршооны харилцааг мөн Хөдөө аж ахуйн хоршооны тухай хуулиар зохицуулж байна. Энэ хуулиас гадна хоршооны үйл ажиллагааг Казахстан Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон бусад эрх зүйн актаар зохицуулдаг.

Судалгаанд хамрагдсан улс орнууд нь ХАА-н салбараа хоршооны зарчмаар амжилттай хөгжүүлж ирсэн ба удирдлагын тогтолцооны хувьд БНСУ, Япон улс нь босоо тогтолцоотой байна. БНСУ-ын Үндэсний ХАА-н хоршоологчдын холбоо нь төрөлжсөн аж ахуйн үйлчилгээ үзүүлдэг, гишүүддээ үйлчилдэг, улс орны хэмжээнд хөдөөгийн хөгжлийн агентлагийн үүрэг гүйцэтгэдэг байна. Үндэсний ХАА-н хоршоологчдын холбоонд 800 гаруй банкны салбар, борлуулалт, боловсруулалтын 600 гаруй аж ахуйн төвүүд, түүнчлэн олон төрлийн аж ахуйн нэгжүүд нэгдэн үйл ажиллагаа явуулдаг. Хамтран ажиллах тогтолцоог бий болгосноор Засгийн газраас ХАА-н салбарын үйл ажиллагааг дэмжих, ХАА хөрөнгө, хангамжийг нэмэгдүүлэх, ХАА-н бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, ургац хураалт, технологийн шинэчлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт зэрэгт ихээхэн нэгдмэл бодлоготой болж, салбарын үйл ажиллагаа шуурхай, шударга, цогц хэлбэрээр явагдах нөхцөл бүрдсэн гэж үздэг.

---

[1] International Co-operative Alliance, https://www.ica.coop/en/cooperatives/facts-and-figures

[2] https://www.samvirkene.no/english/

[3] http://icao.coop/ourwork/01_sdg.htm?tmenu=&smenu=sub3&stitle=subtitle3_1&page=1&board=1&items=&key=&no=35&mode=detail&page=1

Японы ХАА-н хоршоо нь 3 шатлал бүхий бүтэцтэй бөгөөд хот, тосгоны түвшний орон нутгийн нэгжийн хөдөө аж ахуйн хоршоод нь эхний буюу 1-р шатлалыг, ХАА-н хоршоодын Мужийн Төв эвсэл нь хоёр дахь шатлал буюу тухайн мужийн бүхий л ХАА-н хоршоодыг хамарна. Гурав дахь шатлал нь Үндэсний хэмжээнийх буюу Японд үйл ажиллагаа явуулж буй бүхий л ХАА-н хоршоодыг хамарч, төв байгууллага нь ерөнхий удирдлагаар хангадаг байна.

Норвегийн хөдөө аж ахуйн хоршоод нь 17 компаниас бүрддэг ба тэдгээр нь бие даасан фермерүүдийн өмчлөлийн хоршоо хэлбэрээр зохион байгуулагдсан. Боловсруулалт ба бүтээгдэхүүн борлуулалт, санхүүгийн үйлчилгээ, үржил болон хээлтүүлэг, ХАА-н тоног төхөөрөмжийн жижиглэн худалдаа зэрэг дөрвөн үндсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг. Бүх хоршоод нь Norsk Landbrukssamvirke компаниар дамжуулан хамтран ажилладаг бөгөөд фермерүүд бүх үйл ажиллагаагаа хоршооны хэлбэрээр явуулдаг байна.

БНКазУ хөдөө аж ахуйн хөгжлийг эрчимтэй дэмжих хүрээнд 2015 онд Хөдөө аж ахуйн хоршоодын тухай хуулийг баталсан бөгөөд ингэснээр хөдөө аж ахуйн хоршооны үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Түүнээс гадна хоршоо нь хоршооны тухай дүрэмтэй байх бөгөөд түүнд тухайн хоршооны үйл ажиллагааг нарийвчлан тусгадаг байна.

БНКазУ-ын Засгийн газраас ХАА-н хоршоодын үйл ажиллагааг тууштай дэмждэг бөгөөд энэ хүрээнд төрөөс хөрөнгө оруулалт, татварын таатай орчин, бүртгэлийн асуудлыг хялбаршуулах, мэдлэг, мэдээллээр хангах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

ХАА-н хоршоодын борлуулалтыг дэмжих гол арга хэмжээ нь бөөний борлуулалт-түгээлтийн төвийн сүлжээ бий болгох явдал юм. Энэ нь өөрийн гэсэн агуулахтай, худалдаа явуулах талбайтай бөгөөд ХАА-н бүтээгдэхүүнийг хадгалах, савлах, борлуулах, тээвэрлэх бүх үйлчилгээг шийдсэн борлуулалт логистикийн төвлөрсөн цэг байна. Мөн түүнчлэн эрүүл ахуйн, гаалийн болон бусад зөвшөөрлийн үйл ажиллагааг нэг дор шийдвэрлэсэн байна. Энэ нь ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон уг бүтээгдэхүүнийг худалдан авагчдыг холбосон талбар байх бөгөөд 2023 оны хагас жилийн байдлаар 9-н бөөний борлуулалт-түгээлтийн төвийг байгуулсан бөгөөд цаашдаа БНКазУ-ын бүх том хотод байгуулахаар төлөвлөж байна.

ХБНГУ дахь хоршоо /Deutsche Genossenschafts- und Raiffeisenverband e.V. (DGRV)/-д нь 150 гаруй жилийн түүхтэй ба 1846 онд Ф.В.Райффайзен гишүүдийнхээ тэгш эрхийг хүндэтгэсэн, харилцан бие биедээ туслах зарчимд тулгуурласан “Ядуу фермерүүдийн өөртөө туслах холбоо” нэртэй хадгаламж зээлийн хоршоог үүсгэн байгуулснаар ХБНГУ-ын хөдөө аж ахуйн салбарт томоохон эргэлт хийсэн гэж үздэг байна. ХБНГУ-д хоршоодын үйл ажиллагааг 1889 онд батлагдсан Хоршооны тухай хуулиар зохицуулж байна. Тус хуульд 2006 онд Европын хоршоодтой холбоотой нэмэлт, өөрчлөлт орсон. ХАА-н хоршоодын эргэлт жилд 50 тэрбум евро байх ба үүнээс 50% нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, харин үлдсэн 50% нь шатахуун түгээх станц, барилгын материалын худалдаа болон хүнсний зах зээл эзэлж байна.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

ХОРШООНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ

2020 онд Монгол Улсад 4468 хоршоо бүртгэлтэй, нийт 234,633 гишүүнтэй, хувь нийлүүлсэн 49.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, тэдний 3670 нь орон нутагт, 798 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг байна[4]. Тэдний гуравны нэг нь бөөний болон жижиглэнгийн худалдаа, 30 хувь нь ХАА-н салбарт мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр ажилладаг байна.

Хоршооны бусад аж ахуйн нэгжээс ялгагдах гол онцлог түүний зарим шинж чанарт оршиж байна. Хоршоо нь нэг талаас иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн байгуулж, нийгэмлэг харилцаан дээр тулгуурладаг хэсэг хүмүүсийн холбоо, нөгөө талаас нь авч үзвэл гишүүдийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ашиг орлоготой ажиллаж байж оршин тогтнож байгаа аж ахуйн нэгж юм[5].

Монгол Улсын Хоршооны тухай хуулийн 4.1.1-т: *“Эдийн засгийн болон нийгэм, соёлын* ***нийтлэг хэрэгцээгээ*** *хангах зорилгоор хэд хэдэн этгээд* ***сайн дураараа нэгдсэн,*** *ардчилсан хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан* ***хуулийн этгээдийг*** *хоршоо гэнэ”* хэмээн заажээ. Эдгээр тодорхойлолтонд хоршооны үндсэн 3 онцлогийг янз бүрийн боловч ижил агуулгаар тусгасаныг харж болно. Үүнд:

- гишүүдээ дэмжих нийтлэг зорилготой;
- сайн дураар эвлэлдэн нэгдсэн;
- аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг.

Хоршооны тухай тодорхойлолт нь компани, ТББ зэрэг бусад хуулийн этгээдийн тодорхойлолтоос ялгаатай бөгөөд хоршооны дараах онцлог шинжийг тусгавал зохино гэсэн байна.[6] ***Нэг дэх нь*** хоршооны хамтын зарчим бөгөөд гишүүд нь хоршооны хамтын үүсгэн байгуулагч байх бөгөөд хоршоог хамтарч санхүүжүүлнэ. Хоршоог хамтарч өмчилж, хамтдаа удирдаж, хянаж, хоршооны үйлчилгээг хамтдаа хэрэглэж, хоршооны өр төлбөр, алдагдлыг хамтарч хариуцна. ***Хоёр дахь нь*** хоршоо хөрөнгө оруулж, их хэмжээний ашиг олохыг эрмэлзэхээс илүү гишүүдээ дэмжиж, тэдний нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулахад анхаарна.

Хоршооны төрөл

Хоршоог эрхэлж буй үйл ажиллагааных нь чиглэлээр хоёр үндсэн хэсэг болгон ангилдаг. Үүнд:

1) Үйлчлэн зуучлах чиглэлтэй,
2) Үйлдвэрлэлийн чиглэлтэй.

Үйлчлэн зуучлах хоршоо **нь** гишүүдийн бүтээгдхүүн, түүхий эд, барааг худалдан авч зуучлан борлуулах, гишүүдээ хэрэгцээт бараа болон шаардлагатай техник, тоног төхөөрөмж, материалаар хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа

[4] (ҮСХ-ны мэдээ).
[5] Б.Зарыккан. Хоршооны тайлбар толь лавлах, 2004.
[6] ОУХБ, Хоршооны тухай хууль тогтоомж боловсруулахад зориулсан зөвлөмж, 2005.

явуулдаг, гол төлөв гишүүд нь үйлдвэрлэл эрхэлдэг, хоршоо нь тэдэнд дэмжлэг үзүүлдэгээрээ онцлогтой.
Гишүүд нь бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч-худалдан авагчийн үүрэгтэй байдаг учир хоршоо гишүүдийн хоорондын харилцааг нарийн зохицуулах шаардлагатай.

Үйлдвэрлэлийн хоршоо **нь** өөрөө бараа бүтээгдхүүн үйлдвэрлэдэг бөгөөд гишүүд нь түүний үйл ажиллагаанд биечлэн оролцож, хоршооныхоо үйлдвэрлэлийг өргөтгөхийг илүү их сонирхдог, шаардлагатай бол гишүүд хоршооны бараа, бүтээгдхүүнийг өөрсдөө худалдан авдаг, гишүүдээ ажлын байраар хангахад илүү их анхаардгаараа үйлдвэрлэлийн хоршоодын ач холбогдол тодорхойлогдоно. Түүнчлэн үйлдвэрлэлийн хоршоо нь гишүүдийн түүхий эдийг авч түүнд үндэслэн үйлдвэрлэл явуулдаг хэлбэртэй байж болдог. Үйлдвэрлэлийн хоршооны үйлчилгээ нь нийтэд нээлттэй байдаг.

Монгол дах хоршооны эрх зүйн зохицуулалт

Хоршооны тухай хууль /шинэчилсэн найруулга/ нь 8 бүлэг 56 зүйлтэй бөгөөд хоршооны хөгжлийг дэмжихтэй холбогдсон цогц харилцааг зохицуулахад чиглэсэн, хоршооны бусад хуулийн этгээдээс ялгарах онцлог буюу өмчлөлийн харилцаа, хамтын удирдлага, хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

- Хоршоо үйл ажиллагаандаа баримтлах зарчмыг тодорхойлсон;
- Хоршооны гишүүний эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгасан: хоршооны гишүүний эрх, үүрэг, бүртгэл, элсэлт, оруулсан хувь хөрөнгө, өв залгамжлал, түүний бүрэн эрх дуусгавар болохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан;
- Хоршооны эрх, үүрэг, хүлээх хариуцлагын талаарх зохицуулалтыг хуульд оруулсан: хуулийн этгээд болохын хувьд хоршоо анх удаа гишүүдийнхээ нийгэм, эдийн засгийн байдлыг дээшлүүлэхтэй холбогдсон үүргийг хуулиар хүлээх болсон;
- Хоршооны өөрийн хөрөнгийн зохицуулалтыг тодорхой болгож, хоршоо зээлдэгч байх боломжийг бүрдүүлсэн: Өмнөх хуульд хоршооны бүх хөрөнгө гишүүдийн нэр дээр давхар бүртгэлтэй байхаар заасан нь санхүүгийн байгууллагаас зээл авах боломжийг хязгаарлаж байсныг өөрчилж, хоршооны өөрийн хөрөнгийг хуулиар тодорхойлж, гишүүдийнхээ дундын өмчийн эд хөрөнгө дээр үйл ажиллагаа явуулдаг онцлогийг нь харгалзсан нягтлан бодох бүртгэлийн журам, зааврыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах зохицуулалтыг оруулсан;
- Хоршооны талаарх төрийн байгууллагын эрх хэмжээг тогтоосон;
- Хоршооны эрсдэлийн удирдлагыг шинэ түвшинд гаргасан: хоршоо үйл ажиллагаа явуулахдаа гишүүдийнхээ дундын эд хөрөнгөд хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлэх явцад үүсэж болох аливаа санхүүгийн хүндрэлийг хохирол багатай даван туулахад бодлогоор дэмжих зорилгоор “Болзошгүй эрсдэлээс хамгаалах сан” болон “Хоршооны хөгжлийн сан”-д тодорхой хөрөнгө төвлөрүүлэх боломжтой болсон

- Хоршооны эд хөрөнгийн хариуцлагын тогтолцоог шинэчилсэн: Хоршоо үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг хоршооны эд хөрөнгөөр хариуцна. Түүнчлэн хоршооны гишүүний бусдын өмнө хүлээх үүргийг хоршоо хариуцахгүй бөгөөд өмнөх хуульд гишүүний нөхөх хариуцлагын хэмжээг хязгаарлах эсэхийг хоршоо өөрийн дүрмээр зохицуулах заалттай байсныг гишүүн гагцхүү хоршоонд оруулсан хөрөнгөөрөө хариуцлага хүлээхээр өөрчиллөө.
- Хоршооны зуучлалын орлогыг албан татвар ногдох орлогоос хасах асуудлыг холбогдох хуульд нэмсэн;
- Хоршооллын салбарын холбоодын үйл ажиллагааны чиглэл, эрх хэмжээ, чиг үүргийг тодорхой болгож, хууль хоорондын зөрчлийг арилгасан.

Хоршоо хуулийн этгээдийнхээ хувьд арилжааны банк болон бусад этгээдээс зээл авах эрх зүйн үндэс бүрдсэнээр хоршоо бие даан хөгжих боломжтой болж, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг хоршоодын хөгжлийг дэмжин орон нутагт хоршооллын хөдөлгөөнийг түгээн дэлгэрүүлэхэд тулхэц болохоор байна[7].

Монгол Улсын дараах хуулиуд хоршооны үйл ажиллагаатай шууд холбогдож, эрх зүйн харилцааг зохицуулдаг:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Хоршооны тухай хууль
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДААС ГАРГАСАН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТУУД

Нэгдсэн Үндэсний Байгууллагын тогтоол: НҮБ-ын 54-р Ерөнхий Ассамблейн 54-р чуулганд дэлхийн 34 орон “Нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүрэг” тогтоолыг санаачлан оруулж нийтийн тохиролцоогоор батлуулжээ.
Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага: 2002 онд Женев хотноо хуралдсан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-ын Ерөнхий бага хурлын 90-р хуралдаанаараа *“Хоршооллын хөгжилд дэмжлэг үзүүлэх тухай”* 193-р зөвлөмжийг батлсан.
Олон Улсын Хоршооллын Алъянс: 1895 онд Лондон хотноо Олон Улсын Хоршооллын Алъянс[8] (ОУХА) байгуулагдсан. ОУХА нь ОУ-ын хоршооллын үндэсний холбоод, хоршооллын бусад байгуулагуудыг нэгтгэж, тэднийг төлөөлөх, тэдэнд үйлчлэх, хоршооллын хөдөлгөөнийг хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг, бие даасан ОУ-ын ТББ юм.

Олон улсын хоршооны үндсэн зарчим

1-р зарчим. Сайн дурын нээлттэй гишүүнчлэл
Хоршоо сайн дурын байгууллага бөгөөд түүний үйлчилгээг гишүүдийнхээ хариуцлагыг хүлээх чадвартай хэн бүхэн ашиглах боломжтой. Гишүүдийг хүйс,

[7] *Улсын Их Хурлын Тамгын газар https://www.parliament.mn/nn/15484/*
[8] International Co-operative Alliance

нийгмийн байдал, шашин шүтлэг, арьс өнгө, улс төрийн үзэл бодлоор гадуурхахгүй, хэн боловч гишүүнээс өөрийн хүсэлтээр гарч, дахин элсэх эрхтэй.

2-р зарчим. Гишүүдийн ардчилсан удирдлага, хяналт
Хоршоо нь бодлого чиглэл, шийдвэр гаргахад идэвхтэй оролцогч гишүүдийн байгууллага юм. Сонгуулиар үүрэг хүлээсэн эрэгтэй, эмэгтэй ямар ч хүн бүх гишүүдийн өмнө тайлан тавина. Анхан шатны хоршоонд гишүүд санал өгөх тэгш эрхтэй байдагтай адил бүх шатны хоршоог ардчилсан хэлбэрээр зохион байгуулна.

3-р зарчим. Гишүүдийн эдийн засгийн оролцоо
Гишүүд хоршооныхоо хөрөнгийг аль болох тэнцүү хэмжээгээр бүрдүүлж, ардчилсан хяналт тавина. Ямар ч тохиолдолд энэхүү хөрөнгийн зарим хэсэг нь хоршооны нийтийн өмч байна. Гишүүд орлогыг дараах зориулалтаар хуваана: Хоршоог хөгжүүлэх нөөц сан байгуулах; Гишүүдийн ноогдол орлого; Гишүүдийн зөвшөөрсөн бусад арга хэмжээ.

4-р зарчим. Хоршооны бие даасан байдал
Хоршоо, гишүүдийн хяналтад байдаг, бие даасан, өөртөө туслах байгууллага юм. Хэрэв тэд өөр байгууллагатай гэрээ байгуулах эсвэл гадны эх үүсвэрээс хөрөнгө эргэлтэнд оруулбал юуны өмнө гишүүдийн ардчилсан хяналтын дор, хоршооны бие даасан тусгаар байдлыг хангахаар тохирч тусгуулна.

5-р зарчим. Боловсрол, сургалт, мэдээлэл
Хоршоо нь гишүүд, удирдлага, ажилтнуудынхаа хоршооны хөгжилд оруулах хувь нэмрийг ахиулах зорилгоор тэднийг боловсрол олгох сургалтад хамруулна. Тэд олон нийтийн ялангуяа залуучууд, тэргүүлэх ажилтнуудад хоршооны ашиг тус, мөн чанарыг ойлгуулна. Хоршоонд сургалт, мэдээллийг дэмжих зорилгоор боловсрол, мэдээллийн хороо, боловсрол, сургалтад зориулсан сан байгуулж болно.

6-р зарчим. Хоршоод хоорондын хамтын ажиллагаа
Хоршоод өөрийн гишүүдэд аль болохоор үр ашигтай үйлчлэхийн зэрэгцээ орон нутаг, олон улсын түвшинд хамтарч ажилласнаар хоршооллын хөдөлгөөнийг улам бэхжүүлнэ. Үүний тулд дундын хоршоонд элсэнэ, хоршоодын холбоонд эвлэлдэн нэгдэнэ, эдийн засгийн гадаад харилцаанд бие даан орно.

7-р зарчим. Нийтийн эрх ашиг
Хоршоо гишүүдийнхээ батламжилсан бодлогоор дамжуулан оршин буй орон нутгийнхаа тогтвортой хөгжлийг хангахын төлөө ажиллана.

Дэлхийн практикт хоршоо нь ОУ-ын гэрээ, хэлэлцээр, тухайн орны хуулиар хориглоогүй үйл ажиллагааг түгээмэл эрхэлж байна. Тухайлбал: газар түрээслэх, хадлан бэлчээрийн, дуудлага худалдааны, жимсний, намаг хатаах, орон сууц барих, тахир дутуу хүмүүсийн, ус сувгийн, ой модны аж ахуйн, зохиомол хээлтүүлгийн, атар эзэмших, намаг хатаах, загас агнуур, боловсруулалтын, ажиллах хүч хуваарилах буюу хөдөлмөрийн, хяналтын, ХАА-н машины, даатгалын, цахилгаан хангамжийн, иргэдийн үйлчилгээний, сургалтын гэх мэт тухайн орон нутагтаа зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг хоршоод эрхэлдэг байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

БНСУ

1. БНСУ дахь хөдөө аж ахуйн хоршооны туршлага, ерөнхий мэдээлэл

Тус улс ХАА-н салбарыг хоршооны зарчмаар амжилттай хөгжүүлж чадсан орнуудын нэг юм. Анх 1960-аад оны эхээр Засгийн газраас ХАА-н бүтээмжийг нэмэгдүүлэх, ХАА-н фермерүүдийн оролцоотойгоор нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах зорилгоор хоршооны тогтолцоог бий болгож, Үндэсний ХАА-н хоршооллын холбоо /NACF/ буюу Хөдөө аж ахуйн хоршооллын дээд байгууллагыг байгуулжээ. Улмаар ХАА-н хоршооллын системийг босоо тогтолцоогоор зохион байгуулж, 1961 онд “Хөдөө аж ахуйн хоршооны тухай хууль”-ийг баталсан байна.

БНСУ ХАА-гаа 6 чиглэлээр */газар тариалан, мал аж ахуй, загас агнуур, хүн орхоодой, жимс жимсгэнэ, цагаан будаа/* түлхүү хөгжүүлж ирсэн бөгөөд өмнө нь байсан ХАА-н банк зэрэг байгууллагууд дээр суурилан богино хугацаанд бизнесийн системийг бий болгож хоршоодыг 2 түвшинд зохион байгуулсан байна. Тухайлбал,

- Анхан шатны ХАА-н хоршоо:
  - *бүс нутгийн хоршоо:* хөдөө орон нутагт засаг захиргааны дүүрэгт зохион байгуулсан /Бүс нутгийн ХАА-н хоршоодын Бүс нутгийн Мал аж ахуйн хоршоод/,
  - *тусгай түүхий эдийн хоршоо:* Жимс, ногоо болон цэцэг үржүүлгийн үйл ажиллагаа явуулдаг хоршоод, мал аж ахуй болон хүн орхоодойн үйлдвэрлэгч нарыг хэлнэ.
- Үндэсний ХАА-н хоршоологчдын холбоо.

Одоо БНСУ 2 сая гишүүнтэй 1360 анхан шатны хоршоо үйл ажиллагаа явуулж байна. БНСУ-ын бараг өрх бүр ХАА-н үйлдвэрлэгч учраас хөдөө аж ахуйн хоршоо нь төрөлжсөн аж ахуйн үйлчилгээг хангадаг, гишүүддээ үйлчилдэг, улс орны хувьд хөдөөгийн хөгжлийн агентлагийн үүрэг гүйцэтгэдэг байна. Харин Үндэсний ХАА-н хоршоологчдын холбоонд 800 гаруй банкны салбар, борлуулалт, боловсруулалтын 600 гаруй аж ахуйн төвүүд, түүнчлэн олон төрлийн аж ахуйн нэгж */сургалтын байгууллага, хөдөө аж ахуйн хоршооллын коллеж, фермерүүдийн сонин/*-үүд нэгдэн үйл ажиллагаа явуулдаг. Эдгээрийн үйл ажиллагаа нь гишүүдийнхээ аж ахуй, борлуулалт, өргөн хэрэглээний бараа, зээл, банк, даатгал, агуулах, тээвэр, нийгэм, соёлын бусад үйл ажиллагааг дэмжихэд чиглэнэ.

Хамтран ажиллах тогтолцоог бий болгосноор Засгийн газраас ХАА-н салбарын үйл ажиллагааг дэмжих, ХАА-н хөрөнгө, хангамжийг нэмэгдүүлэх, ХАА-н бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, ургац хураалт, аж ахуйн технологийн шинэчлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт зэрэгт ихээхэн нэгдмэл бодлоготой болж, салбарын үйл ажиллагаа шуурхай, шударга, цогц хэлбэрээр явагдах нөхцөл бүрдсэн гэж үздэг.

2. БНСУ дахь хөдөө аж ахуйн хоршооны эрх зүйн орчин

ХАА-н хоршооны салбарын үйл ажиллагааг Хөдөө аж ахуйн хоршооны тухай хуулиар (Agriculatural Cooperative Law) зохицуулж байна. Тус хууль нь 1988 онд нэмэлт өөрчлөлт орсон. 8 бүлэг 175 зүйлтэй[9]. Үүнд:

- 1-р бүлэг: Нийтлэг үндэслэл;
- 2-р бүлэг: Анхан шатны Хөдөө аж ахуй хоршоо;
- 3-р бүлэг: Хүчингүй болсон;
- 4-р бүлэг: Тусгай Хөдөө аж ахуйн хоршоо;
- 5-р бүлэг: Үндэсний Хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны холбоо;
- 6-р бүлэг: Хяналт тавих;
- 7-р бүлэг: Хүлээлгэх хариуцлага;
- 8-р бүлэг: Нэмэлт.

Хуульд “хоршоо болон холбооны хамтын ажиллагааны зорилго нь аливаа бизнесийн үйл ажиллагаанд ялгаварлан гадуурхахгүй, бүх гишүүдэд адил тэгш үйл ажиллагаа явуулах боломж олгох, гишүүдийн эрх ашгийг хамгаалах, нэгдмэл зорилгын дор сайн дураар нэгдэх явдал юм” гэж тодорхойлжээ.

Хуульд зааснаар анхан болон тусгай шатанд нэг үйл ажиллагааны чиглэлээр хичнээн ч хоршоо байгуулж болох бөгөөд хоршооны гишүүн нь фермерийн хамтын ажиллагааны гишүүн байж болно. Гишүүн нэгээс дээш жил хамтын үйл ажиллагаа явуулаагүй бол гишүүнээс хасах асуудал хөндөгдөнө. Хоршоо нь 200-аас доошгүй гишүүнтэй байх ба 2 жил тутам хугацаа сунгаж явна. Гишүүд нь эргэлтийн хөрөнгө оруулалт хийх бол хувьцааг бүртгүүлж оролцоно. Хоршооны ерөнхийлөгч нь хоршоог төлөөлнө. Ерөнхийлөгчийг хоршооны гишүүдийн саналаар тодорхой шалгуурыг хангасан хүнийг сонгоно. Харин Үндэсний ХАА-н хамтын ажиллагааны холбоо нь 15-аас доошгүй хоршоодын үйл ажиллагааг дэмжин ажилладаг байх шаардлагатай. Мөн хоршоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Засгийн газарт төлөөлөх, үйл ажиллагааны төлөвлөгөө тайланг сайдад танилцуулах үүрэгтэйгээс гадна хоршоодын үйл ажиллагаа чиглүүлэн, хяналт тавих үүрэгтэй.

Хоршооны хамтын үйл ажиллагааг зөрчсөн болон хөрөнгө хууль бусаар захиран зарцуулах, зээл, санхүүгийн тайлан худал мэдүүлсэн, үүсгэн байгуулах баримт хуурамчаар үйлдсэн, холбооны дүрмийг ноцтой зөрчсөн тохиолдлуудад 10 000 000 воноор торгох эсхүл 10 хүртэл жил хорих ялаар шийтгэх зэргээр хамтын үйл ажиллагааны хариуцлагыг хатуу чанд зохицуулсан байна.

Хуулийн 58-р зүйлд Хоршоодод үзүүлэх үйлчилгээ тухайлбал, зээл, борлуулалт, даатгал, олон нийтийн үйлчилгээ, банкны үйлчилгээ, хөрөнгө оруулалтын талаар мөн зохицуулсан байна.

Энэхүү хуулиар хоршоод болон холбооны үйл ажиллагаа, зохион байгуулалт, удирдлага, хяналт, хүлээлгэх хариуцлагыг тодорхой зохицуулсан байна.

3. БНСУ дахь хөдөө аж ахуйн хоршооны борлуулалт, хангамж

[9] Agricultural cooperatives law https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EB%86%8D%EC%97%85%ED%98%91%EB%8F%99%EC%A1%B0%ED%95%A9%EB%B2%95


БНСУ-д Үндэсний Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо (NACF) хөдөө аж ахуйн нэгдсэн борлуулалтын үйл ажиллагааг илүү үр ашигтай байдлаар хүнсний түгээх төвүүдээр дамжуулан нэгдсэн байдлаар зохион байгуулдаг. Үндэсний ХАА-н Хоршооллын холбооны хүнсний түгээлтийн төвүүд нь ХАА-н бөөний борлуулалтын захаасаа илүү сайн үйл ажиллагаатай байдаг байна.

Энэхүү ХАА-ын нэгдсэн борлуулалтын тогтолцоо нь фермерүүд болон хэрэглэгчдийн хоорондох маш сайн харилцаа холбоо болохоос гадна хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, борлуулалтыг түргэн шуурхай болгоход чухал үүрэгтэй юм.

БНСУ-ын ХАА-н захын тогтолцоо ба хоршооллын хүнс түгээн борлуулах төвүүдийн нөхцөл байдал

Борлуулалтын нэгдсэн тогтолцоо нь жижиг фермерүүд ба жижиг хүнсний худалдаачдаас бүрэлдэнэ. ХАА-н бүтээгдэхүүн борлуулалтын сүлжээ нь дараах шат дамжлагаар явагдана.

ХАА-н бүтээгдэхүүн борлуулалтын нэгдсэн сүлжээ



Анхан шатны түвшинд ХАА-н бүтээгдэхүүнүүдийг гол төлөв орон нутгийн хоршооллууд (43%), орон нутгийн зуучлагчид (26%), эсхүл орон нутгийн захууд (15%)-аар түгээж байна. Нэгдсэн борлуулалтын түвшинд жимс болон хүнсний ногоог бөөний захууд, Үндэсний ХАА-н Хоршоологчдын холбооны борлуулалтын төвүүд ба худалдаалах газрууд, усан тээвэр эрхлэгчдийн хоорондох шууд борлуулалтаар дамжин борлуулагддаг.

ХАА-н бүтээгдэхүүний гол борлуулагддаг газрууд бол хямдралтай агуулах худалдаа, супермаркет, их дэлгүүр болон жижиг хүнсний дэлгүүрүүд юм. Харин томоохон хүнсний худалдааны газрууд нь ХАА-н бүтээгдэхүүнийг шууд орон нутгийн хоршоолол, фермерийн холбоо зэрэг орон нутгийн усан тээвэрлэгчдээс худалдан авах замаар өөрсдийн байр суурийг бэхжүүлж иржээ.

Хямдралтай агуулах худалдааны газруудын жилийн нийт худалдаа 1996 онд 2,1 их наяд байсан бол 2014 онд 47,5 их наяд вон болж өссөн байна. Нийт бүтээгдэхүүний худалдааны 58,6 хувь нь хүнсний бүтээгдэхүүн байгаагаас цэвэр хүнс 26.4 хувь, боловсруулсан хүнс 27,3 хувь байна.

Агуулах худалдааны газруудын тоо өсөхийн хэрээр Супермаркетуудын нийт худалдааны тоо хэмжээ бас өссөн. Ялангуяа, E-Mart, Homeplus, Lotte Mart гэх зэрэг хямдралтай агуулах дэлгүүрүүдийн салбар жижиг болон дунд хэмжээний супермаркетуудын тоо сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, орон нутгийн уламжлалт багахан хүрээтэй дэлгүүрүүдийн байрыг эзлэх болжээ.

(Нэгж: Их наяд вон)

	Нийт дэлгүүрийн худалдаа	Их дэлгүүр	Супер маркет	Хямдралтай агуулах худалдаа
1996	90.9	12.5	6.3	2.1
2000	117.7	15.2	6.3	10.6
2004	151.4	16.5	11.5	21.5
2007	231.7	18.7	11.8	28.9
2014	359.7 (100.0)	29.3 (8.1%)	35.4 (9.8%)	47.5 (13.2%)

Тайлбар: 2015 оны ханшаар 1 ам доллар 1,200 Солонгос вонтой тэнцэнэ.

ХАА-н бүтээгдэхүүн, ялангуяа жимс ба хүнсний ногооны борлуулалтад агуулах худалдааны зах чухал үүрэгтэй байдаг. БНСУ-ын нэгдсэн худалдааны зах болон хувийн нэгдсэн худалдааны зах гэсэн хоёр төрлийн агуулах худалдааны зах байдаг. Тухайлбал,

- улсын агуулах худалдааны захууд нь төв болон орон нутгийн захиргааны төсвөөр байгуулагдаж, үйл ажиллагааг нь орон нутгийн захиргаанаас эрхлэн явуулна;
- хувийн агуулах худалдааны захууд нь өмнө нь ХАА-н бөөний худалдааны зах хэлбэрээр төвлөрч байгаад сүүлийн жилүүдэд улсын бөөний худалдааны нэгдсэн захууд олширсноос ач холбогдол нь багасч тоо нь буурчээ.

Агуулах худалдааны захын гол үйл ажиллагаа нь бараа татах, түгээн борлуулах, төлбөр, үнийн мэдээлэл, зах зээлийн мэдээллийг цуглуулах ба түгээх байдаг. Худалдааны аргууд нь дуудлага худалдаа 90 хувь, хувийн тохиролцоо 10 хувь байдаг бол үйлчлүүлэгчид захиргааны албадууд, хоршоодын холбооны худалдаачид, бөөний захын худалдаачид, хэрэглэгчид байдаг байна.




Тайлбар: Гарак Агуулах худалдааны захын борлуулалтын систем

ХАА-н бүтээгдэхүүн борлуулалтын 40 хувийг ХАА-н хоршоологчдын холбооны төвүүд эзэлж байна.

Орон нутгийн хоршооллууд нь борлуулалтын төвүүдийн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг бөгөөд эдгээрийг барьж байгуулах санхүүжилтийн зарим хэсгийг Засгийн газраас нөхөн олгодог. Үүнд RPC /будаа боловсруулах төвүүд/ ба APC /ХАА-н бүтээгдэхүүн боловсруулах төвүүд/ багтана.

NACF-ын Хүнсний бөөний борлуулалтын төвүүд нь хүнсний худалдааны захуудтай харьцуулахад үнэ, өртгийн зөрүү багатай, хувийн тохиролцоогоор худалддаг, нэгдсэн үйл ажиллагаатай. Одоогоор 15 нэгдсэн хүнс борлуулалтын төв ажиллаж байна. Тус борлуулалтын төв нь бараа хүлээж авах, задлах, шалгах, хүлээн авах, арчлах, агуулан хадгалах, нэгдсэн дүн гаргах, сонгох, сэргээн засах, нөөцлөх, боох, сортлох, тавиурт өрөх, ачих/усаар тээвэрлэх, захиалга авах, баримтжуулах, эргэлтийг тооцох, бүртгэлд хяналт тавих, ажиглах үйл ажиллагаа явуулна. Нийт борлуулалтын 46% жимс, 45.4% хүнсний ногоо, нийт борлуулалтын 8.4% нь органик эсхүл шавьж устгалын бодисгүй жимс, хүнсний ногоо, нийт борлуулалтын 7% цэвэр бүтээгдэхүүн эзэлж байна. Нэгдсэн борлуулалтын төв нь жимс, хүнсний ногоог голчлон орон нутгийн хоршооллууд, орон нутгийн хоршооллуудын холбооноос худалдаж авдаг.

NACF-ын Нэгдсэн хүнс борлуулах төвүүдийн үйл ажиллагаа




NACF-ын хүнсний бөөний борлуулалтын төвүүдийн баримталж ажиллаж буй гол зарчмууд нь:

- Жижиглэн худалдааны үйлчлүүлэгчид болон орон нутгийн хоршооллуудын сонирхолыг адил тэгш, үр дүнтэй хангах;
- Зөвхөн сайн бүтээгдэхүүнээр хангаад зогсохгүй жижиглэн худалдааны үйлчлүүлэгчдэд маш сайн үйлчлэх;
- Захиалга, хангалт, хүргэлт, үйл ажиллагаа зэргийг тээвэр зуучлалын орчин үеийн үйлчилгээгээр хангах;
- Автоматчлал, стандартчлал, жин хэмжүүр, хөдөлмөрийн хөлсийг бууруулах гэх зэргээр тээвэр зуучлалын өртгийг бууруулах;
- Борлуулалтын төвийн бизнесийн амжилтанд үйлчлүүлэгчдийн жижиглэн худалдааг дэмжих, үйлчлүүлэгчдийн боловсрол, сургалт, зөвлөгөө өгөх үйлчилгээнүүдийг явуулах;

- Олон талт худалдааны гарцуудыг нэмэгдүүлэх зорилгоор хямдралтай худалдаа ба супермаркетын тоог өсгөх шаардлагатай;
- Ажилтнуудын боловсрол сургалтыг сайжруулах, бөөний худалдаанд борлуулалтын менежер, тээвэр зуучлалын менежер, худалдааны менежер гэх зэрэг хангалттай мэргэжилтэн бэлтгэхэд анхаарах зэрэг болно.

Нийлүүлэлтийн урсгалын менежментийн VMI (Vendor Managed Inventory-Худалдааны зохицуулалтын жагсаалт) дэвшилтэт технологийг хэрэгжүүлснээр жижиглэнгийнхэн худалдаагаа борлуулалтын төв рүү захиалж, улмаар борлуулалтын төв нь усан тээврийнхэнд захиалгаа өгөх боломжтой болсон байна.



ЯПОН УЛС

1. Хөдөө аж ахуйн хоршооны туршлага, ерөнхий мэдээлэл

Японы Хөдөө аж ахуйн хоршоо[10] (農業協同組合) нь 3 шатлал бүхий бүтэцтэй бөгөөд хот, тосгоны түвшний орон нутгийн нэгжийн ХАА-н хоршоод нь эхний буюу 1-р шатлалыг, ХАА-н хоршоодын Мужийн Төв эвсэл хоёр дахь шатлал буюу тухайн мужийн бүхий л ХАА-н хоршоодыг хамарна. Гурав дахь шатлал нь Үндэсний хэмжээнийх буюу Японд үйл ажиллагаа явуулж буй бүхий л ХАА-н хоршоодыг хамарч, төв байгууллага нь ерөнхий удирдлагаар хангадаг байна.

Японы ХАА-н хоршоод нь Дэлхийн II дайны дараахь ХАА-н шинэтгэлийн бодлогын хүрээнд 1947 онд батлагдсан ХАА-н хоршооны тухай хууль[11] (農業協同組合法)-иар зохицуулагдаж байна. Хуульд заасны дагуу ХАА-н хоршоо нь бүтээгдэхүүний тээвэрлэлт, үйлдвэрлэл, агуулах, борлуулалт зэрэг үйл ажиллагаанаас гадна, банк санхүү, даатгал, эрүүл мэнд зэрэг хүний өдөр тутмын амьдралын бүхий л чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Японы хөдөө аж ахуй эрхлэгч бүр ХАА-н хоршоодод хамаарах бөгөөд газраа худалдах, даатгалд хамрагдах, зээл авах зэрэг газар, хөдөө аж ахуйтай холбоотой бүхий л гүйлгээ хоршооны банкаар дамждаг нь ХАА-н хоршоодын банк, даатгалын бүтцийг бэхжин, томроход ихээхэн нөлөөлсөн бөгөөд Японы ХАА-н хоршоодын ашгийн ихэнх хувийг банк санхүү, даатгалын салбар бүрдүүлж байна.

1940-1980-аад онд төрөөс банк, санхүүгийн салбарт хатуу, чанга бодлого барьж байсан хэдий ч ХАА-н хоршоодыг дэмжих бодлого явуулж, ХАА-н


[10] Японы Хөдөө аж ахуйн хоршоо https://life.ja-group.jp/message
[11] Хөдөө аж ахуйн хоршооны тухай хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=322AC0000000132_20230601_504AC0000000061

банкуудад хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн байдаг. Тухайлбал, ердийн арилжааны банктай харьцуулбал салбар нэгж байгуулахад хөнгөлөлт эдлэх, банк хоорондын зах зээлийн замаар хотын банкуудад зээл олгохыг зөвшөөрсөн, мөн хугацаатай хадгаламжийн хүүг бусад арилжааны банкуудаас өндөр тогтоох давуу эрх олгосон байна.

Японы Хөдөө аж ахуйн хоршооны дээд байгууллага “JA Group” /*Japan, Agriculture гэх хоёр үгний нийлбэр*/ нь 694 орон нутгийн хоршооноос бүрдэх, 10 сая гаруй гишүүнтэй байгууллага юм. Бүтцийн хувьд 3 шатаас бүрдэх бөгөөд хот, тосгоны түвшний орон нутгийн нэгжийн ХАА-н хоршоод нь анхан шат буюу 1-р шатлалыг бүрдүүлнэ. Хөдөө аж ахуйн хоршоодын Мужийн Төв эвсэл нь хоёр дахь шатлал буюу тухайн мужийн бүхий л ХАА-н хоршоог хамарна. Гурав дахь шатлал нь Үндэсний хэмжээнийх буюу Японд үйл ажиллагаа явуулж буй бүхий л ХАА-г хамарч, ерөнхий удирдлагаар хангадаг байна.

JA Group нь Zenchu, Zenkyoren, Norinchukin Bank, Zen-Noh, болон “Бусад” буюу группын гишүүдийн нийгмийн баталгаа хангах зорилго бүхий элементээс бүрдэж байна. Zenchu нь аудит, сургалт, ХАА-н бодлого, олон нийттэй харилцах зэрэг JA Group-ыг ерөнхий удирдлагаар хангана. Zenkyoren нь гишүүддээ даатгалын үйлчилгээ үзүүлэх бөгөөд амь нас, үл хөдлөх хөрөнгө болон авто тээврийн хэрэгслийн даатгал зэргийг хамарна. Norinchukin Bank нь зээл, хадгаламж зэрэг өдөр тутмын амьдралд шаардагдах төрөл бүрийн санхүүгийн үйлчилгээ үзүүлнэ. Zen-Noh нь ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай түүхий эд, материал, тоног төхөөрөмж зэргээр хангах бөгөөд борлуулалтыг хариуцна. Бусад гэгдэх нэгж нь нийгмийн халамжийг хариуцах бөгөөд аялал жуулчлалыг хөгжүүлэх, JA-ын өдөр тутмын сонин сэтгүүл болон бусад ХАА-н хэвлэлийг хариуцна. Өнөөдрийн байдлаар 47 мужаас 35-д нь Zen-Noh мужийн төв штаб үйл ажиллагаагаа явуулж байна.

JA Group-ийн бүтэц, зохион байгуулалтын бүдүүвч



Эх сурвалж: http://zhiusa.com/home/about/ja-structure/

Анхан шатны хоршоод нь хөдөө аж ахуй эрхлэгчидтэйгээ шууд холбоотой ажиллана. ХАА-н эрхлэгч, фермер нь анхан шатны ХАА-н хоршооны энгийн гишүүн байна. Ердийн гишүүдээс гадна ХАА-н хоршоодод фермер бус гишүүн байж болох бөгөөд гишүүн болохын тулд тухайн хоршооныхоо үндсэн зарчмуудыг хүлээн зөвшөөрсөн байна. Аль ч гишүүн ХАА-н хоршооноос үзүүлж буй үйлчилгээ авах эрхтэй байдаг боловч зөвхөн ердийн гишүүн нь Хоршооны хуралд санал өгөх эрхтэй байна. Мөн ХАА-н хоршооны Ерөнхийлөгчийг ердийн гишүүд дундаас сонгоно.

2. Хөдөө аж ахуйн хоршооны эрх зүйн орчин

Хөдөө аж ахуйн хоршоотой холбоотой харилцааг 1947 онд батлагдсан Хөдөө аж ахуйн хоршооны тухай хуулиар зохицуулж байна. Тус хууль 2022 оны шинэчилсэн найруулгаар 10 бүлэг 106 зүйлээс бүрдэх бөгөөд дараахь агуулгатай:

- 1-р бүлэг: Нийтлэг үндэслэл
- 2-р бүлэг: Хөдөө аж ахуйн хоршоод болон Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо
- 3-р бүлэг: Хөдөө аж ахуйн хоршооллын нэгдэл
- 4-р бүлэг: Байгууллагын өөрчлөлт
- 5-р бүлэг: Зээлийн бизнесийн тусгай агентлаг
- 6-р бүлэг: Маргаан шийдвэрлэх байгууллага
- 7-р бүлэг: Хяналт шалгалт
- 8-р бүлэг: Бусад
- 9-р бүлэг: Торгууль
- 10-р бүлэг: Хураамж хураах журам

Хууль нь ХАА-н хоршооллын байгууллагыг хөгжүүлэх, ХАА-н бүтээмжийг нэмэгдүүлэх, хоршооллийн гишүүдийн эдийн засаг, нийгмийн байдлыг сайжруулах, улмаар улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

Хөдөө аж ахуйн хоршооны хуулийн голлон холбогдох нь Монополийн эсрэг хууль[12] (昭和二十二年法律第五十四号（私的独占の禁止及び公正取引の確保に関する法律）-ийн 22 дугаар зүйлийн хоршоо болон жижиг аж ахуйн нэгжүүдэд тусгай журам үйлчлэхийг зөвшөөрсөн заалт байна. “Монополийн эсрэг хууль нь шударга бус худалдааны нөхцөлийг тогтоосон, эсхүл аливаа нэг салбар дахь өрсөлдөөн хязгаарлагдсаны улмаас шударга бус үнийн өсөлт бий болсноос бусад тохиолдолд хоршоодод үйлчлэхгүй. Хоршоод нь доорх жагсаалтад дурдсан нөхцөлүүдийг хангасан байна:

1. Хоршооны зорилго нь жижиг үйлдвэрлэгч нар, эсхүл хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх байна;
2. Хоршоог сайн дурын үндсэн дээр байгуулна, гишүүд нь сайн дурын үндсэн дээр нэгдэж, гарах эрхтэй байна;

[12] Монополийн эсрэг хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=322AC0000000054

3. Гишүүн бүр адил саналын эрхтэй байна;
4. Ашгийг гишүүд дунд хуваах нь хүндрэлтэй нөхцөлд хуваарилалтыг хууль болон хоршооны дүрэмд зааснаар шийдвэрлэнэ.” гэж заажээ.

ХАА-н хоршоо нь дээр дурдсан шударга бус өрсөлдөөн, аль нэг салбарт үндэслэлгүй үнийн өсөлт бий болгосноос бусад тохиолдолд Монополийн эсрэг хуулийг дагаж мөрдөхгүй юм. Тухайлбал, ХАА-н хоршооны фермерүүд нь бүгд тохиролцож ХАА-н бүтээгдэхүүнээ нэг үнээр борлуулах бол энэ нь Монополийн эсрэг хуулиар хориглосон картельд тооцогдохгүй юм.

Монополийн эсрэг хуулиар ХАА-н хоршоодоор дамжуулж ХАА-н бүтээгдэхүүн борлуулах, нийлүүлэх зэргийг хориглоогүй хэдий ч дараах гурван үйл ажиллагаанд Монополийн эсрэг хууль үйлчилнэ:

1.анхан шатны хоршоо нь фермерүүдэд ердийн компаниар дамжуулан ХАА-н бүтээгдэхүүнээ борлуулах, шаардлагатай бараа бүтээгдэхүүнээ худалдан авахгүй байхыг шаардах;
2.анхан шатны хоршоо нь дундын хэрэглээний ХАА-н тоног төхөөрөмж, барилга байгууламжийг ашиглуулах тохиолдолд зөвхөн анхан шатны хоршоодоор дамжуулан бүтээгдэхүүний борлуулах, худалдан авахыг шаардах;
3.нэгжийн хоршоод нь ХАА-н зээл олгохдоо ХАА-н хоршоогоор дамжуулан бүтээгдэхүүний борлуулах, худалдан авах нөхцөл тавих.

Ерөнхий сайд асан Ш.Абегийн Засгийн газар 2014 оноос хойш ХАА-н салбарыг шинэчлэхээр ажилласан бөгөөд “Шинэ өсөлтийн стратеги” төлөвлөгөөндөө холбогдох зарим асуудлыг тусгасан. 2016 оны 4 сараас Японы хөдөө аж ахуйн хоршооны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Хуульд тусгагдсан нэмэлт, өөрчлөлтүүд нь ХАА-н хоршоодын тоо буурсантай холбогдуулан ХАА-н хоршооны Үндэсний холбооны эрх мэдлийг сулруулах, орон нутгийн нэгжүүдийг илүү бие даасан тогтолцоотой болгоход чиглэгдсэн байна. Төв эвслээс орон нутгийн нэгжүүдэд явуулах аудит болон удирдлагаар хангадаг байдлыг халж 2019 оны 10-р сараас эхлэн орон нутгийн нэгжүүд нь өөрсдөө аудитын байгууллагаа сонгох эрхтэй болсон.

3. Хөдөө аж ахуйн хоршооны борлуулалт, хангамж

Японы Анхан шатны хоршоод нь гишүүддээ бордоо, хортон шавьж устгагч, тэжээл болон ХАА-н машин техникээр хангах үйлчилгээ үзүүлэх бөгөөд хоршоодын худалдаж авсан үнэ нь фермерүүдэд өгч байгаа үнээс дээгүүр байдаг нь шимтгэл авдагтай холбоотой байна. Үүнийг “нэгдсэн худалдан авалт”[13] гэх бөгөөд энэ нь Анхан шатны хоршооны голлох үйл ажиллагааны нэг юм. Нэгдсэн худалдан авалтаас гадна “нэгдсэн тээвэрлэлт” байх бөгөөд Анхан шатны хоршоод нь фермерүүдээс ХАА-н бүтээгдэхүүнийг цуглуулж цааш нь дамжуулан худалдана. Худалдан авалттай адил нэгдсэн тээвэрлэлтэд фермерүүд шимтгэл төлнө. Эдгээр нь Анхан шатны хоршоодын ашгийн гол эх үүсвэрүүд юм.

Анхан шатны хоршоод нь энгийн хувийн компаниудтай өрсөлдөж, шаардлагатай бүхнээр хангаж, ХАА-н бүтээгдэхүүнийг цуглуулж борлуулдаг юм.

[13] Борлуулалт хангамж https://www.maff.go.jp/j/pr/aff/2203/spe1_01.html


Гэхдээ хувийн компаниудтай харьцуулбал Анхан шатны хоршоодын хязгаарлагдмал хөрөнгө, хүний нөөц нь том компаниудтай өрсөлдөхөд хүндрэлтэй болгодог. Энэхүү сул талыг нөхөхийн тулд анхан шатны хоршоод нь муж болон үндэсний хэмжээнд холбоод байгуулсан байна. Эдгээр холбоодыг Keizairen болон Zen-noh гэнэ.

Японы ХАА-н хоршоологчдын орлогыг нэмэгдүүлэх, нэмүү өртгийн сүлжээг өргөжүүлэх тал дээр тодорхой арга хэмжээ авч ажилласан бөгөөд тэдгээр нь:

- Хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ шууд зарж, борлуулах фермерийн захуудыг ажиллуулах;
- бизнес экспо-гоор дамжуулах маркетингийн сүлжээгээ өргөжүүлэх;
- бусад салбаруудтай нэгдэн экспортыг нэмэгдүүлэх зэрэг байна.

Keizairen буюу мужийн түвшний эдийн засгийн холбоод нь Хөдөө аж ахуйн хоршоодын дор байгуулагдсан нэгж байх бөгөөд хөдөө аж ахуй эрхлэгчдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг цуглуулах, боож баглах, борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.


ХАА-н бүтээгдэхүүний нэгдсэн борлуулалт, хангамжийн бүдүүвч



Цагаан будаа

Япон жилд дунджаар 8.1 сая тонн цагаан будаа үйлдвэрлэдэг бөгөөд төрөл бүрийн шугамаар хэрэглэгчдэд хүрч байна. JA Group нь тус шугамын 44 хувийг, ZEN-NOH нь 33 хувийг тус тус хангадаг байна.


Цагаан будааны борлуулалт, хангамжийн бүдүүвч



Мах, махан бүтээгдэхүүн

Мах, махан бүтээгдэхүүн нь бусад ХАА-н бүтээгдэхүүнээс ялгаатай нь нядалгаа шаардлагатай байдаг. Энэ нь борлуулалт, нийлүүлэлтэд тодорхой хязгаарлалтуудыг бий болгодог. Бод мал болон гахайн нядалгаа нь үйлдвэрлэлийн орчим дахь махны төвүүд, эсхүл хэрэглэгчдийн ойролцоох махны бөөний захуудад явагддаг. Харин тэндээсээ хэрчиж, хуваасан махыг савлаж жижиглэн болон хоолны үйлчилгээний газруудад түгээдэг байна. Тахиаг дээрх газрууд бус тахианы үйлдвэрт цээж, гуя болон бусад төрлөөр боловсруулдаг байна. Үүний дараагаар үхэр болон гахайн махны адилаар хөлдөөх, эсхүл жижиглэнгийн худалдаанд хүрдэг байна.

Мах, махан бүтээгдэхүүний борлуулалт, хангамжийн бүдүүвч



БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

1. Хөдөө аж ахуйн хоршооны туршлага, ерөнхий мэдээлэл

Казахстан Улс хөдөө аж ахуйн салбарын үр ашгийг нэмэгдүүлэх, ХАА-н салбар дахь жижиг, дунд үйлдвэрлэгчдийн бүтээмжийг өсгөх зорилгоор 2000 оны эхээр ХАА-н хоршооны үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлж эхэлсэн. Улмаар 2015 онд Хөдөө аж ахуйн хоршоодын тухай хуулийг боловсруулан гаргаснаар (*2016 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн*) хөдөө аж ахуйн хоршоод олноор бий болж, Засгийн газраас тэдгээрийн үйл ажиллагааг тууштай дэмжих бодлого явуулсан.

2021 оны байдлаар Казахстан Улсад 2919 ХАА-н хоршоо, 49379 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна[14]. 2017 оноос хойш хөдөө аж ахуйн хоршоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор төрөөс дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна:

- Хөрөнгө оруулалтын зориулалт бүхий санхүүгийн тусламж, хөнгөлөлт;
- ХАА-н бүтээгдэхүүний өртгийг бууруулах арга хэмжээ;
- Татварын онц таатай нөхцөл бий болгох, үүнд бүх төрлийн татварт 70% хүртэлх хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;
- Бүртгэл, зөвшөөрлийг хялбаршуулах;
- Маркетинг, мэдээллийн дэмжлэг;
- Санхүүгийн дэмжлэг.

Засгийн газраас ХАА-н хоршоодод үзүүлэх санхүүгийн дэмжлэг тогтвортой өссөн байна. Тухайлбал, лизингийн санхүүжилт 2020 онд 2017 онтой харьцуулахад 155% өсөж, 114 тэрбум тэнгэ[15] хүрсэн. Харин хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг 20.4% өсөж, 260.5 тэрбум тэнгэ хүрсэн. 2017 онд 67.3 тэрбум тэнгэний хөнгөлөлттэй зээл олгож байсан бол 2020 онд 86.2 тэрбум тэнгэний хөнгөлөлттэй зээл олгожээ[16].

Дээр дурдсан арга хэмжээний хүрээнд олон тооны хоршоод байгуулагдан амжилттай үйл ажиллагаа явуулж байна. Жишээ нь:

1. Павлодар мужийн “Ертис-Агро” хоршоо нь 40 гишүүнтэй. Эдгээр хөдөө аж ахуй эрхлэгчид хоршоо байгуулснаар шатах тослох материал, бордоо, хортон шавжийн эсрэг бэлдмэлийг хямд үнээр худалдан авах боломж бүрдсэн. Мөн бүтээгдэхүүнээ хамтран бөөнд нь үр ашигтай борлуулах болсон. Түүнчлэн, тухайн хоршоо нь хөнгөлөлттэй зээлээр элеватор худалдан авсан бөгөөд хоршооны гишүүд дундаа өмчлөх болсон байна.
2. Костанай мужийн “Успеновка Сут” хоршоо нь сүү үйлдвэрлэгчдийг нэгтгэдэг. Энэ хоршоо сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “МИЛХ” компанитай гэрээ байгуулж 1 литр сүүг 110 тэнгэгээр тогтмол нийлүүлэх

[14] Об утверждении Концепции развития агропромышленного комплекса Республики Казахстан на 2021 – 2030 годы, Постановление Правительства Республики Казахстан от 30 декабря 2021 года № 960., Раздел 2, 2.6. Сельскохозяйственная кооперация и инфраструктура АПК, **https://adilet.zan.kz/rus/docs/P2100000960#z197**

[15] Казахстан Улсын мөнгөний нэгж. (2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Монгол банкны ханшаар 1 тэнгэ 7.71 төг байна)

[16] Об утверждении Концепции развития агропромышленного комплекса Республики Казахстан на 2021 – 2030 годы, Постановление Правительства Республики Казахстан от 30 декабря 2021 года № 960., Раздел 2, 2.10. Государственная поддержка, https://adilet.zan.kz/rus/docs/P2100000960#z197

болсон. Ингэснээр бүтээгдэхүүнээ борлуулах баталгаат худалдан авагчтай болж чадсан.

3. Умард-Казахстан мужид ХАА-н хоршоонд зориулсан хөнгөлөлттэй зээлийн төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүний үр дүнд Умард-Казахстан мужид 21 сүүний ферм байгуулагдаж, сүүний үйлдвэрлэл нь жилд 648 мянган тонн хүрсэн бөгөөд энэ нь Казахстан Улсын нийт сүүний үйлдвэрлэлийн 10.3%-ийг бүрдүүлэх болсон.

Хэдийгээр ХАА-н хоршооны талаарх энэ мэт сайн жишээ их боловч сөрөг үр дагавар бас цөөнгүй гарсан. 2018 оны хяналт шалгалтаар нийт бүртгэлтэй хоршоодын 18% хуурамч хоршоо байсан бол 42% нь төрийн хөнгөлөлтөд хамрагдах зорилготой “цаасан дээрх” хоршоо байсан байна[17].

Түүнчлэн орон нутагт ХАА-н хоршоо амжилттай зохион байгуулахад дараах бэрхшээлүүд тулгарч байна:

- Хоршоог хангалттай сайн зохион байгуулаагүйгээс болж ХАА эрхлэгчдийн хоршоонд итгэх итгэл буурсан.
- Хоршооны үйл ажиллагаа хийгээд зохион байгуулалтын талаар хангалттай ойлголтгүй.
- Эрх зүйн орчин хангалттай бус.
- Төрийн үйл ажиллагаа нь оновчтой хүрч ажиллаагүй.

Хөдөө аж ахуй нь Казахстан Улсын эдийн засагт онцгой байр суурь эзэлдэг чухал салбарын нэг учраас Төрийн тэргүүн болон Засгийн газрын зүгээс энэ салбарыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьдаг байна.

Төрийн тэргүүн Касым-Жомарт Токаев 2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн “Олон нийтийн тулгамдсан яриа хэлэлцээ-Казахстан Улсын тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийн үндэс” илтгэлдээ энэ салбарын хувьд цаашид анхаарах асуудлуудыг онцлон дурдсан байна. Төрийн тэргүүн илтгэлдээ ХАА-н аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх, мөн хөдөө аж ахуй нь улс орны гол баялаг хэдий ч бүх боломж, бололцоо бүрэн дүүрэн ашиглагдаагүй байгааг онцолсноос гадна газар тариалангийн талбайг үр дүнтэй хөгжүүлэх, тариаланчдад бүтээгдэхүүнээ экспортлоход нь бүх талын дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд татах асуудлыг онцлон дурджээ.

2. Хөдөө аж ахуйн хоршооны эрх зүйн орчин

Казахстан Улсын хөдөө аж ахуйн хоршооны харилцааг Хөдөө аж ахуйн хоршооны тухай хуулиар зохицуулж байна. Энэ хуулиас гадна хоршооны үйл ажиллагааг Казахстан Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон бусад эрх зүйн актаар зохицуулдаг.

[17] Мониторинг развития сельскохозяйственной кооперации в Казахстане, OECD, https://www.oecd.org/eurasia/competitiveness-programme/central-asia/Kazakhstan-Monitoring-Agricultural-Co-operatives-2019-RUS.pdf

Хөдөө аж ахуйн хоршооны тухай хууль[18] нь хоршооны үйл ажиллагааг зохицуулдаг гол хууль бөгөөд 2015 онд батлагдаж, 2016 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн. Хуулиар ХАА-н хоршооны гишүүдийн эрх зүйн байдал, эрх ба үүргийн талаар, түүнчлэн ХАА-н хоршоо болон хоршооны холбоодын эрх зүйн байдал, хоршоо байгуулах, хоршооны үйл ажиллагаа, хоршоог өөрчлөн байгуулах болон тараах журмын талаар тус тус зохицуулсан. Хууль 7 бүлэг 32 зүйлтэй байна:

1 бүлэгт ерөнхий зүйлийн талаар, үүнд хуулийн зохицуулах харилцаа, хуульд хэрэглэгдэх үндсэн ойлголтууд, ХАА-н хоршоодын талаарх эрх зүйн зохицуулалтууд, хоршоо байгуулах, түүний үйл ажиллагааны үндсэн зорилго болон зарчмууд; хоршооны эрх зүйн байдал, хоршооны үйл ажиллагааны төрөл, хоршооны хөдөө аж ахуйн болон аква үржүүлгийн (загас үржүүлгийн аж ахуй) бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагааны талаар, үйлдвэрлэлд шаардлагатай хэрэгсэл, материал техникийн нөөцөөр хангах талаар, хоршооны үзүүлэх үйлчилгээний талаар;

2 дугаар бүлэгт хөдөө аж ахуйн хоршоог хөгжүүлэх чиглэлээрх төрийн зохицуулалтын тухай, үүнд төрийн байгууллагууд болон хөдөө аж ахуйн хоршоодын харилцаа, хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн цогцолборыг хөгжүүлэх чиглэлээрх эрх бүхий байгууллагын бүрэн эрх, орон нутгийн төлөөллийн (маслихат) болон гүйцэтгэх (захиргааны) байгууллагуудын бүрэн эрхийн талаар;

3 дугаар бүлэгт хөдөө аж ахуйн хоршоо байгуулах тухай, үүнд, хоршоо байгуулах журам, хоршооны гишүүдийн хуралд тавигдах шаардлага, хоршооны дүрмийн талаар, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, батлах болон хоршооны салбар, төлөөлөгчийн газрын талаар;

4 дүгээр бүлэгт хөдөө аж ахуйн хоршооны хөрөнгийн тухай, үүнд, хоршооны хөрөнгийг бүрдүүлэх эх үүсвэр, хоршооны гишүүдийн оруулах хөрөнгийн хувь хэмжээ, төлөх хураамж, хоршооны гишүүдийн эд хөрөнгийн хариуцлага, гишүүний хураамж, хоршооны цэвэр ашгийг гишүүдэд хуваарилах талаар;

5 дугаар бүлэгт хөдөө аж ахуйн хоршооны гишүүнчлэл, үүнд, хоршооны гишүүд болон хоршооны холбоодын гишүүдийн эрх эрх зүйн байдал, тэдгээрийн эрх, хоршооны гишүүдийн үүрэг, хоршооны гишүүд болон хоршооны холбоонд гишүүнээр элсүүлэх, хоршооны гишүүнээс татгалзах, хоршооны гишүүнчлэлээс гаргах, хоршооны гишүүдийн өрийг барагдуулах, хоршооны гишүүний хууль ёсны өв залгамжлал, хоршоог өөрчлөн байгуулахтай холбогдох эрхийн талаар;

6 дугаар бүлэгт хөдөө аж ахуйн хоршооны удирдлагын тухай үүнд, хоршооны удирдлагын тогтолцоо, гишүүдийн хурал, хоршооны удирдлага, хоршооны санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгах, хоршооны хянан шалгах

[18] **О сельскохозяйственных кооперативах**
Закон Республики Казахстан от 29 октября 2015 года № 372-V ЗРК.,
https://adilet.zan.kz/rus/docs/Z1500000372

зөвлөл, санхүүгийн үйл ажиллагаанд хийгдэх аудитын тухай болон хоршоодын холбооны талаар;

7 дугаар бүлэгт хөдөө аж ахуйн хоршоог дахин байгуулах, тараах талаар тус тус зохицуулсан байна.

Хөдөө аж ахуйн хоршоо нь хоршооны тухай дүрэмтэй байх ба түүнд тухайн хоршооны үйл ажиллагааг нарийвчлан зохицуулдаг. Хоршооны дүрмийг хоршооны гишүүдийн хурлаар хэлэлцүүлж батлах бөгөөд дүрмийг боловсруулахдаа Казахстан Улсын Хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Хөдөө аж ахуйн хоршооны загвар дүрмийг батлах тухай”[19] No1-2/1117 дугаар бүхий тушаалын дагуу батлагдсан загвар дүрмийг ашиглана.

Хоршооны дүрэмд дараах зүйлийг заавал тусгана:

- Хоршооны нэр, эрх зүйн байдал;
- Аж ахуйн нэгжийн статус;
- Хоршооны байршлын хаяг;
- Хоршоо байгуулах зорилго болон үйл ажиллагааны төрөл;
- Хоршооны удирдлагын байгууллагыг бүрдүүлэх журам, тэдгээрийн бүрэн эрх, шийдвэр гаргах журам;
- Хоршооны гишүүдийн ээлжит, ээлжит бус болон бусад хурлыг хуралдуулах журам;
- Хоршоонд гишүүн элсүүлэх журам, тавигдах шаардлага, гишүүнчлэлээс татгалзах журам;
- Хоршооны гишүүнчлэлээс гаргах үндэслэл, журам;
- Хоршооны гишүүд болон хоршоодын холбооны гишүүдийн эрх ба үүрэг;
- Хоршооны хөрөнгийг бүрдүүлэх эх үүсвэр;
- Хоршооны гишүүдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, гишүүнчлэлийн хураамжийн тухай;
- Гишүүдийн хоршооны үйл ажиллагаанд оролцох оролцоо, журам;
- Хоршооны төлбөрийг төлөх болон орлогыг хуваалцах журам;
- Хоршооны өр төлбөрийг барагдуулах журам, шаардлага;
- Хоршооны гишүүдийн хурлын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах журам;
- Сангийн төрөл, сангийн хөрөнгийн хэмжээ, санг бүрдүүлэх болон зарцуулах журам;
- Хоршоо үйл ажиллагааны төрлөө өөрчлөхөд тавигдах шаардлагууд;
- Хоршоог өөрчлөн байгуулах болон тараах үндэслэл зэрэг болно.

3. Хөдөө аж ахуйн хоршооны борлуулалт, хангамж

Казахстан Улсын ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн хөгжилд чөдөр тушаа болж буй нэг хүчин зүйл нь бүтээгдэхүүн борлуулалт, хангамжийн дэд бүтэц болж байна. Казахстан Улсад хүнсний ногоо, мах, сүү, ноос зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хангамжийн 50%-ийг жижиг, дунд үйлдвэрлэгчид

[19] Об утверждении типового устава сельскохозяйственного кооператива, Приказ Министра сельского хозяйства Республики Казахстан от 24 декабря 2015 года № 1-2/1117., https://adilet.zan.kz/kaz/docs/V1500012685

бүрдүүлдэг. Гэтэл хөдөө аж ахуй эрхлэгчдийн (жижиг дунд үйлдвэрлэгчид) үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн хэрэглэгчийн гарт хүрэх үйл явц нь “дундын наймаачдаар” дамжин явагдаж байна. Өөрөөр хэлбэл, дундын наймаачид хөдөө аж ахуйн хоршооны гишүүдийн бүтээгдэхүүнийг шууд худалдан авч хот суурин газар аваачин бөөнөөр худалдаж байна. Жишээ нь хүнсний ногооны хувьд “дундын наймаачид” тариалангийн талбайгаас нь худалдан авч байгаа бол, мах махан бүтээгдэхүүний хувьд “дундын наймаачид” тухайн малыг худалдан авч нядлан (эрүүл ахуйн стандарт хангагдсан эсэх нь эргэлзээтэй) махыг нь бөөнөөр борлуулж байна.

Бүтээгдэхүүн тээвэрлэлтийг “дундын наймаачид” өөрсдөө хийх бөгөөд тээврийн хэрэгсэл нь ихэнхдээ тухайн “дундын наймаачдын” мэдлийнх байдаг.

Дундын наймаачид нь хөдөө аж ахуй эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг борлуулах үр ашигтай систем болж чаддаггүй. Үүнд:

- Хэрэв хөдөө аж ахуй эрхлэгчийн бүтээгдэхүүний хэмжээ хангалттай их биш бол (жишээ нь машин нь дүүрэхгүй бол) бүтээгдэхүүнийг нь очиж худалдан авдаггүй.
- Дундын наймаачид нь бүх зардлаа нөхөх, их хэмжээний ашиг олохын тулд үнээ 2-3 дахин нэмэгдүүлэх нь элбэг. Ингэснээр үйлдвэрлэгч бүтээгдэхүүнээ бага үнээр зарж, харин хэрэглэгчид өндөр үнэтэй бүтээгдэхүүн худалдан авах болдог.
- Тээврийн хэрэгсэл нь хуучирсан, зориулалтын бус байдаг тул бүтээгдэхүүний чанар мууддаг.
- Даатгалын систем байхгүй тул “дундын наймаачид” нь бүх эрсдэлээ өөрөө даах болдог. Энэхүү эрсдэлийн зардлаа барааны үнэд шингээдэг.
- Бүтээгдэхүүн тээвэрлэлт, хуваарилалтын нэгдсэн системгүй тул төрийн зүгээс зохицуулалт хийх боломж бага байдаг.

Дундын наймаачид нь хоршоологчдоос худалдан авсан бүтээгдэхүүнээ тухайн хот суурин газрын хүнсний захуудад аваачиж бөөнөөр худалдаалдаг байна. Эдгээр хүнсний захууд нь ихэвчлэн бөөний худалдааны хэсэгтэй байх бөгөөд тээврийн хэрэгслээсээ эсвэл лангуунаас худалдаалж болдог. Хэрэглэгч нь бөөний худалдааны хэсгээс шууд худалдан авах боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл, хүнсний зах нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтыг зохион байгуулж байна. Энэхүү борлуулалтын схем олон сул талтай. Үүнд:

- Борлуулалт, хангамжийн дэд бүтэц хөгжөөгүй.
- Маш олон тооны дундын дамжлагаар дамжин бүтээгдэхүүн хэрэглэгчид хүрдэг.
- ХАА-н хоршоодын гишүүд болон жижиглэнгийн худалдаачдын хооронд холбох дэд бүтэц байхгүй.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт, хуваарилалтын явцад гарах зардал өндөр, хорогдол их.
- Хөдөө аж ахуйн хоршоодын бүтээгдэхүүнийг борлуулах тогтвортой, баталгаат зах зээл бий болоогүй.

- Хөдөө аж ахуйн хоршоодын бүтээгдэхүүнийг экспортлох зохион байгуулалттай систем байхгүй.

Ингэснээр хүнсний бүтээгдэхүүн үнэ өндөр, улирлын үнийн хэлбэлзэл их бөгөөд нийлүүлэлт нь тогтвортой бус болж байна.

Казахстан Улсын Засгийн газраас хөдөө, аж ахуй эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг Хөдөө, аж ахуйн хоршоодын үйл ажиллагаагаар дамжуулан дэмжих бодлого барьж байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн хоршоогоор дамжуулан боловсруулах үйлдвэрүүдэд бүтээгдэхүүнээ борлуулах боломжийг бий болгох;
- Хөдөө, аж ахуйн хоршоодын гишүүдийн бүтээгдэхүүнийг борлуулах “Бөөний борлуулалт-түгээлтийн төв”-үүдийг барьж байгуулах;
- Экспортын үйл ажиллагааг дэмжих;
- Хөдөө аж, ахуйн хоршоодын бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулах маркетингийн үйл ажиллагааг (үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, олон улсын арга хэмжээнд оролцох г.м) зохион байгуулах.

ХАА-н хоршоодоор дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулснаар нийлүүлэлтийн хувь хэмжээгээ нэмэгдүүлэх, тээвэрлэлт хийгээд борлуулалтыг хамтын үйл ажиллагаагаар, зардал багатай шийдвэрлэх боломжтой юм.

ХАА-н хоршоодыг тухайн бүс нутаг дахь боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллахад Засгийн газар болон орон нутгийн захиргаанаас захиргааны болон эдийн засгийн дэмжлэг үзүүлдэг.

ХАА-н хоршоодын борлуулалтыг дэмжих гол арга хэмжээ нь Бөөний борлуулалт-түгээлтийн төвийн сүлжээ бий болгох явдал юм. Бөөний борлуулалт-түгээлтийн төв нь өөрийн гэсэн агуулахтай, худалдаа явуулах талбайтай бөгөөд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хадгалах, савлах, борлуулах, тээвэрлэх бүх үйлчилгээг шийдсэн борлуулалт логистикийн төвлөрсөн цэг байна. Мөн түүнчлэн эрүүл ахуйн, гаалийн болон бусад зөвшөөрлийн үйл ажиллагааг нэг дор шийдвэрлэсэн байна. Энэ нь ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон уг бүтээгдэхүүнийг худалдан авагчдыг холбосон талбар байна. Ингэснээр ХАА-н хоршоод нь бүтээгдэхүүнээ бөөний борлуулалт-түгээлтийн цэгт авчрах бөгөөд үйлдвэрлэгчид, жижиглэн борлуулагчидтай гэрээ байгуулан тэдгээрийн худалдан авах, найдвартай бэлтгэн нийлүүлэгчид болох юм.

Бөөний борлуулалт-түгээлтийн төв байгуулах хүрээнд 2017 оноос хойш 800 тэрбум тэнгэ (2 тэрбум илүү ам.доллар) зарцуулахаар төлөвлөсөн. 2023 оны хагас жилийн байдлаар 9 бөөний борлуулалт-түгээлтийн төвийг байгуулсан бөгөөд цаашдаа Казахстаны бүх том хотод байгуулахаар төлөвлөж байна.

НОРВЕГИЙН ХААНТ УЛС

1. Хөдөө аж ахуйн хоршооны туршлага, ерөнхий мэдээлэл

Норвеги Улсын хөдөө аж ахуй нь Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 1.6%-ийг эзэлж, 2023 оны эхний улиралд 5769 сая Норвеги крон болж өссөн байна. Хөдөө аж ахуй нь ажиллах хүчний 2%-ийг эзэлж байна. Нийт нутаг дэвсгэрийн 2.9%-ийг газар тариалангийн бүс нутаг, 0.7%-ийг малын бэлчээр

эзэлдэг байна. Норвеги Улс нь нийт хүснийхээ хэрэглээний тал хувийг дотооддоо үйлдвэрлэдэг бөгөөд мал аж ахуйн бүтээгдэхүүн нь дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг байна. Тус улс нь далайн бүтээгдэхүүний экспортоор дэлхийд хоёрт буюу Хятад Улсын дараагаар ордог. Тус улсад 38076 хөдөө аж ахуйн холдинг үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 1954 нь гэрчилгээ бүхий органик фермийн аж ахуйнууд байна.[20]

Норвегийн фермерүүд бүх салбарт үйл ажиллагаагаа хоршооны хэлбэрээр явуулдаг. Норвегийн хөдөө аж ахуйн хоршоолол нь 100 гаруй жилийн түүхтэй ажээ. Норвеги Улсын хэмжээнд хөдөө аж ахуйн хоршоолол нь 17 фермерийн өмчит хоршоодоос бүрдэж байна.[21] Хөдөө аж ахуйн хоршоод нь 4 үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- Боловсруулалт ба бүтээгдэхүүн борлуулалт;
- Санхүүгийн үйлчилгээ;
- Үржил болон хээлтүүлэг;
- Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийн жижиглэн худалдаа зэрэг болно.

Хоршоод нь Norsk Landbrukssamvirke компаниар дамжуулан хамтран ажилладаг байна. Хоршооны гишүүд нь фермерүүдийн бүтээгдэхүүнийг цуглуулах, шаардлагатай боловсруулалт хийгдсэний дараа бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд хамтран ажилладаг. Хоршоод нь ихэвчлэн нэг төрлийн бүтээгдэхүүн дагнан боловсруулах хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хоршоод анх үүсгэн байгуулагдахдаа орон нутгийн жижиг хоршоод байсан бол яваандаа хоршоод хоорондын хамтын ажиллагаа болон өргөжиж, салбар бүр нь бүс нутгийн болон улс орны өнцөг бүрээс гишүүн элсүүлсэн үндэсний хэмжээний хоршоотой болсон байна. Бүс нутгийн хоршоод нь тухайн бүс нутгийн фермерүүдийн нийтлэг ашиг сонирхлыг дэмжих зорилго бүхий хөдөө аж ахуйн байгууллагуудын хамтын ажиллагааны форум болж 6 бүсэд байршин ажилладаг байна.

Хоршоодын зах зээлд эзлэх хувь маш өндөр ба сүү, сүүн бүтээгдэхүүний салбар дахь боловсруулагдсан бүтээгдэхүүний 90-ээс дээш хувийг, мах, өндөг болон үр тарианы 60-70 хувь, хүнсний ногооны 50 орчим хувийг зах зээлд нийлүүлдэг байна.[22] Засгийн газраас баримталж буй хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэхэд хоршоод ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Хүнс, хөдөө аж ахуйн яам нь Норвеги Улсын хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлж ажиллахыг үндэсний хэмжээний хөдөө аж ахуйн хоршоодод үүрэг болгосон байна. Тэд тохиролцсон зорилтот үнийн хүрээнд тодорхой төрлийн бүтээгдэхүүнийг хамгийн боломжит үнээр зах зээлд нийлүүлэх бодлогыг ханган ажилладаг. Шаардлагатай тохиолдолд хоршоодын гишүүн бус фермерүүдээс ч бүтээгдэхүүн цуглуулах үүргийг хүлээдэг. Энэ нь гэр бүлийн хүрээний фермерүүдийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх боломжийг олгодог.

[20] https://www.bondelaget.no/getfile.php/13894650-1550654949/MMA/Bilder%20NB/Illustrasjoner/Norwegian%20Agriculture%20EN.pdf
[21] https://landbruk.no/om-oss/
[22] https://www.tine.no/english/about-tine/agricultural-cooperatives-in-norway

Нөгөө талаар фермерүүд энгийн өрсөлдөөний дүрмээс гадуур ажиллах боломжтой байдаг. Үүнд:

- Фермерүүд нь өөрсдийн хоршоодоор дамжуулж бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлэхийг зөвшөөрдөг;
- Хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлж байгаагийн хувьд хоршоодыг зах зээлд томоохон хувь эзлэхийг зөвшөөрдөг хэдий ч төрөөс хоршоодын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг байна.[23]

2. Хөдөө аж ахуйн хоршооны эрх зүйн орчин

Норвеги Улсад хоршоотой холбогдон гарах харилцааг 2007 онд батлагдсан Хоршооны тухай хууль (Cooperative Act)[24] –аар ерөнхийд нь зохицуулж байна. Харин хөдөө аж ахуйн хоршооны үйл ажиллагааг дээрх хууль болон Худалдааны тухай хууль (Marketing Act), Аж үйлдвэр, загас агнуурын яамнаас баталсан Хөдөө аж ахуй, загас агнуурын худалдаа, борлуулалтын онцгой нөхцөлийн тухай журам (Regulations on exceptions for cooperation etc. in agriculture and fishing)[25], Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн зохицуулалтын журам (Regulation on market regulation of agricultural goods)[26]-аар тус тус зохицуулж байна. Хоршооны тухай хууль нь 14 бүлэг, 164 хэсэгтэй бөгөөд дараах бүтэцтэй байна. Үүнд:

1-р бүлэг	Хуулийн танилцуулга, хамрах хүрээ
2-р бүлэг	Хоршоог үүсгэн байгуулах
3-р бүлэг	Хоршооны гишүүнчлэл
4-р бүлэг	Санхүүгийн хүчин зүйлүүд
5-р бүлэг	Хоршооны гишүүдийн жил бүрийн уулзалт, хурал
6-р бүлэг	Аж ахуйн нэгжийн удирдлага
7-р бүлэг	Аудит
8-р бүлэг	Хоршоодыг нэгтгэх
9-р бүлэг	Хоршоодыг салгах
10-р бүлэг	Татан буулгах
11-р бүлэг	Хувийн хязгаарлагдмал хариуцлагатай компани болон Нийтийн хязгаалагдмал хариуцлагатай компани болгон хөрвүүлэх
12-р бүлэг	Нөхөн олговор
13-р бүлэг	Шүүхийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм
14-р бүлэг	Хууль хүчин төгөлдөр болох хугацаа болон бусад хуульд оруулах нэмэлт өөрчлөлт.

[23] УИХ-ын Тамгын газрын ПССХ, Хөдөө аж ахуйн салбарыг хоршооны зарчмаар хөгжүүлсэн зарим орны туршлага ба эрх зүйн орчин: Нэгдсэн борлуулалт, хангамжийн тогтолцоо, ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ бүрдэлт СТ-17/204

[24] https://coops4dev.coop/sites/default/files/2021-05/Norway%20Legal%20Framework%20Analysis%20Report.pdf

[25] https://lovdata.no/dokument/SF/forskrift/2004-04-23-651

Аж үйлдвэр, загас агнуурын яам нь Хөдөө аж ахуй, загас агнуурын худалдаа, борлуулалтын онцгой нөхцөлийн тухай журмыг батлан Өрсөлдөөний тухай хууль (Competition Act)-ийн 10, 11-р зүйлд зааснаас гадуур онцгой эрхийг ХАА болон загас агнуурын АА-д олгосон байна.

[26] https://lovdata.no/dokument/SF/forskrift/2008-10-22-1136

Хуулийн 2-р бүлэгт Хоршоог үүсгэн байгуулах тухай зохицуулалтууд орсон ба хоршооны дүрэмд дараах зүйлсийг заавал тусгахаар хуульчилсан. Үүнд :

- хоршооны нэр;
- хоршооны төвийн байнгын бүртгэлтэй хаяг;
- эрхлэх үйл ажиллагааны төрөл;
- гишүүнчлэлийн хураамж төлөх эсэх, хураамж нь хүүтэй эсэх, гишүүнчлэлээс гарахад хураамжийг эргэн төлөх эсэх тухай асуудал;
- жилийн ашгийг юунд ашиглах;
- удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;
- Жил бүрийн уулзалт, хурлаар хэлэлцэх асуудал;
- аж ахуйн нэгж татан буугдсан тохиолдолд хөрөнгийн хуваарилалтыг хэрхэн хийх г.м асуудлыг зохицуулахыг хуульчилсан.

Хуулийн 3-р бүлэгт хоршооны гишүүнчлэлийн асуудлыг 11 зүйлээр зохицуулсан бөгөөд эрх, үүргийг тодорхойлсон байна. Гишүүд нь хоршооны үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцон дараах үүргийг хүлээхээр заажээ:

1. хоршоонд гишүүнээр элсэхдээ хувь нийлүүлэх үүрэгтэй,
2. хоршооноос хууль ёсны дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй,
3. хууль, дүрэмд заасан бусад үүрэг.

Хуулийн 4-р бүлэгт хоршооны санхүүгийн хүчин зүйлсийг 10 зүйлээр нарийвчлан зохицуулсан байна. Хоршоо нь үйл ажиллагааны цар хүрээ болон эрсдэлд үндэслэн хангалттай хэмжээний хөрөнгөтэй байх, жилийн ашгийг хэрхэн хуваарилах, гишүүдэд жилийн ашгаас хувь хүртээхдээ суутгах суутгал болон ашгийн хувийг хэрхэн төлөх (бүхэлд нь буюу хэсэгчлэн), түүнчлэн хоршоод нийлэн нэг холбоонд харьяалагдаж буй ижил төрлийн хоршоодод хувь оруулж болох хийгээд хоршоо нь өөрийн хөрөнгийн хэмжээнд үндэслэн тодорхой хэмжээний зээл болон баталгааг гишүүддээ олгох тухай асуудлыг тус тус хуульчилсан байна.

Хуулийн 5-р бүлэгт хоршооны жил бүрийн хурал, хуралд оролцох гишүүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, санал өгөх эрх болон энгийн хурал, онцгой хурал, хурал зохион байгуулах журам, хурлын шийдвэр, хурлаас хяналтын хороо байгуулах зэрэг асуудлыг зохицуулжээ.

6-р бүлэгт хоршооны удирдлага, удирдах зөвлөлийг хэрхэн сонгох, сонгуульд оролцоход гишүүдийн эдлэх эрх, удирдах зөвлөлд хүйсийн төлөөллийг хангах, хоршооны удирдлагын бүрэн эрхийн хугацаа, удирдлагыг орлох этгээд, цалин хөлс, ерөнхий менежер болон удирдлагуудын тал хувь нь Норвеги Улсын иргэн байх, удирдлагуудын хүлээх үүрэг зэрэг асуудлыг хамран зохицуулжээ.

7-р бүлэгт хоршооны үйл ажиллагаанд хяналт тавих аудиторыг хэрхэн сонгох, аудиторын жилийн тайланг хоршооны хуралд танилцуулах зэрэг асуудлыг хамруулсан бол 8-р бүлэгт хоршоодыг нэгтгэх асуудал, нэгтгэх асуудлыг зохицуулах журам, хоршооны хөрөнгө, өр төлбөрийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх болон эрх, үүргийн талаар зохицуулжээ. Харин 9-р бүлэгт хоршоодыг

салгахад үүсэх нөхцөл байдал, түүнийг хэрхэн зохицуулах тухай хуульчилсан бол 10-р бүлэгт хоршоо тарах тохиолдолд үүсэх нөхцөл байдал зэргийг тус тус зохицуулсан байна. Хоршоо нь үйл ажиллагааны хүрээгээ тэлэн компани болох тухай асуудлыг 11-р бүлгээр, харин хоршооны үйл ажиллагаатай холбоотой аль нэг тал хохирол хүлээсэн тохиолдолд хохирлыг хэрхэн барагдуулах, түүнчлэн хохирол хүлээсэн талд нөхөн олговор олгох талаар 12-р бүлгээр зохицуулсан бол хоршоо болон удирдах зөвлөл, түүнчлэн захирлууд хооронд маргаан үүссэн тохиолдолд хоршоог шүүхэд төлөөлөх этгээдийг сонгох болон Дүүргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хоршооны зүгээс баримтлах зарчмын талаар 13-р бүлгээр зохицуулжээ. 14-р бүлэгт Хууль хүчин төгөлдөр болох хугацаа болон бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

3. Хөдөө аж ахуйн хоршооны борлуулалт, хангамж

Норвеги Улс нь дэлхийн ихэнх орнуудтай харьцуулахад маркетингийн зарим асуудлаа хоршооллын зарчмаар амжилттай шийдвэрлэж чадсан орон юм. Маркетингийн хоршоод нь Норвегийн хөдөө аж ахуйн зах зээлд чухал үүрэг гүйцэтгэдэг. Үндэсний хэмжээний томоохон хоршоод нь сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, өндөг, шувууны зах зээл дэх дотоодын үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтанд 60%-100%-ийг эзэлдэг. Эдгээр дотоодын анхан шатны үйлдвэрлэл нь импортын гаалийн татварын бодлогын хүрээнд хамгаалагдаж байдаг ба дотоодын эрэлт хэрэгцээг бүхэлд нь хангадаг. Тиймээс хоршооны эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэхэд олох ашгийн хэмжээ нь харьцангуй их байдаг. Нөгөө талаас хоршоод нь Засгийн газрын хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэгч хэрэгсэл нь болдог.

Норвегийн маркетингийн хоршоодыг Маркетингийн Зөвлөл хянадаг. Маркетингийн Зөвлөл нь Норвегийн Засгийн газраас олгосон эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Маркетингийн зөвлөлийн үндсэн зорилго нь үнэ бүрдэлтийг хянах, өөрөөр хэлбэл хөдөө аж ахуйн маркетингийн зах зээлийн үйл ажиллагааг тогтворжуулахад оршино. Маркетингийн зөвлөлийг Засгийн газраас санхүүжүүлдэггүй ба сүү, гахай, хонь болон тэжээлийн баяжмалд ногдуулсан борлуулалтын хураамжаар санхүүжилтээ бүрдүүлдэг.

Норвегийн хөдөө аж ахуйн маркетингийн хоршоод нь тус улсын 8 дүүрэгт тархан байршсан. Гурван том маркетингийн төв болох Сүүний төв, Мах болон гахайн махны төв, Өндөгний төв ажилладаг бөгөөд эдгээр төвүүд нь нэг нэгнээсээ хамааралгүйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй фермер нь эдгээр төвүүдийн аль нэгэнд нь харьяалагдаж болох ба нийт фермерүүдийн 75-95 хувь нь эдгээр маркетингийн төвүүдэд харьяалагддаг, харин Өндөгний төвд харьцангуй бага харьяалагддаг байна. Учир нь фермерүүд өндгөө хүнсний бүтээгдэхүүнтэй шууд солилцохыг илүү ашигтай гэж үздэг байна.

Сүүний төвүүд

Норвеги Улс нь сүүний борлуулалтад маш өвөрмөц аргыг ашигладаг ба дэлхийн олон орны маркетингийн хоршооны суралцагчид энэхүү системийг судлахын тулд тус улсад ирдэг байна. Фермерүүдэд шингэн хэрэглээний сүүг нийлүүлэх нь бяслаг болон цөцгийн тосны үйлдвэрлэлд сүү нийлүүлэхээс илүү ашигтай байдаг

ба Маркетингийн зөвлөл энэ асуудлыг сүүний үйлдвэрлэлийн хамгийн гол асуудал мөн болохыг тогтоож асуудлыг шийдвэрлэх арга замыг хайсан байна. Хэрэглээний сүү нь айл бүрийн хэрэглэдэг сүү гэж нэрлэгддэг бол үйлдвэрлэлийн сүү нь бяслаг болон цөцгийн тосыг үйлдвэрлэх явцад хэрэглэгдэж буй сүү хэмээн нэрлэгддэг. Маркетингийн зөвлөл асуудлыг шийдэхээс өмнө хэрэглээний сүүний борлуулалтад өрсөлдөөн маш их байсан ба үүнийг дагаад үнийн өсөлт ч үүссэн. Маркетингийн зөвлөл нь хэрэглээний сүү болон үйлдвэрлэлийн сүүний борлуулалтын үнийн зөрүүг ялгаатай татвар ногдуулалтын аргаар амжилттай шийдвэрлэсэн.

Мах болон гахайн махны төвүүд

Махны борлуулалтын үйл явцад сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтын үйл ажиллагаатай төсөөтэй бодлогыг баримталсан. Маркетингийн зөвлөл нь худалдан борлуулагдсан мал, амьтны тоо толгой бүрт болон үр тарианы борлуулалтад ногдуулсан татвараар санхүүжилтээ бүрдүүлдэг. Тус улсад мал аж ахуйд хангалттай тэжээл өгөхүйц үр тарианы ургац хязгаарлагдмал учраас үр тарианы дийлэнх хувийг импортоор оруулдаг. Фермер бүрийн тодорхой хэмжээний үр тариаг жил болгон татвараас чөлөөлдөг. Харин энэхүү хэмжээнээс давсан тохиолдолд ногдуулсан татварыг төлөх үүрэгтэй. Энэ нь автоматаар их хэмжээний махны үйлдвэрлэлийг хязгаарлаж өгдөг.

Саарал үнэгний үслэгийн үйлдвэрлэл нь Норвегид хөгжиж буй үйлдвэрлэлийн нэг юм. Чанаргүй загас болон махыг зах зээлд хямд үнээр борлуулахын оронд түүгээр үйлдвэрлэлийн зориулалтаар үслэг эдлэлийг нь ашиглах үнэгийг хооллох нь илүү үр өгөөжтэй гэж үздэг. Махны төв бүр дэргэдээ нядалгааны үйлдвэртэй байдгийн зэрэгцээ хоршоодын хэрэглэгчдэд болон бусад жижиглэнгийн махны худалдааны төвүүдэд мах түгээх өөрсдийн борлуулалтын агенттай байдаг.

Өндөгний төвүүд

Өндөгний төвүүд нь сүү болон махны төвүүдийн нэгэн адил зэх зээлд ихээхэн орон зайг эзэлдэггүй хэдий ч энэхүү төвүүд нь үйл ажиллагаагаа үр ашигтай явуулдаг. Засгийн газраас өндөгний зах зээлийн борлуулалтын үнийг тогтоох зөвлөлийг байгуулсан ба зөвлөлийн гишүүдийн 3 нь өндөгний төвүүдээс, 3 нь хувийн өндөг үйлдвэрлэгчдээс, 1 нь Засгийн газраас томилогдсон төлөөлөгч байхаар зохицуулсан. Энэхүү зөвлөл нь өдөр бүр хуралддаг ба тухайн өдрийн өндөгний борлуулалтын үнийг тогтоож өгдөг. Бүх өндөг худалдан борлуулагчид нь тогтоосон үнийг дагах үүрэгтэй. Зөвлөлийн гол зорилго нь бүх төрлийн өндөг үйлдвэрлэгчдэд ашигтай, хамгийн боломжит шударга үнийг тогтооход оршино. Зөвлөл нь шувууны аж ахуйг мөн адил хянах үүргийг хүлээдэг.

Эдгээр гурван томоохон төвүүдээс гадна олон тооны хөдөө аж ахуйн түүхий эдийн үйлдвэрлэлийн төвүүд үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа ба эдгээр нь, хүнсний ногооны, жимсний, модны, ноосны, саарал үнэгний үслэг эдлэлийн гэх мэт борлуулалтын төвүүд юм. Тус улсад үйлдвэрлэгдэж буй хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн нь сүүний, махны болон өндөгний төвүүдийн үйл ажиллагаатай ижил төсөөтэй системээр зах зээлд борлуулагддаг. Ямар ч

тохиолдолд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр нь зах зээлийг зохицуулах тул үйлдвэрлэгчид хувийн агентлагуудын шахалт дарамт, үнийн хэлбэлзлээс хамгаалагдсан байдаг. Хөдөө аж ахуйн түүхий эдийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үнэ ханшинд зуучлагчид хөндлөнгөөс оролцох сонирхолтой байдаг ч хөдөө аж ахуйн хоршооллын оршин тогтнож буй байдал нь бүтээгдэхүүний үнийг хэвийн байлгах хүчин зүйл болдог тул зуучлагчдын энэ салбарт үндэслэлгүйгээр үнийг хөөрөгдүүлэх, монополь эрх эдлэх боломж нь хязгаарлагдмал байдаг.

Норвегийн хөдөө аж ахуйн хоршооллын салбарт баримталж буй хөдөө аж ахуйн түүхий эдийн үйлдвэрлэл болон үнийг зохицуулах систем нь фермерүүдэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд нь тохирсон шударга үнийг тогтоож олгох, хэт үйлдвэрлэлээс сэргийлэх зорилготой юм. Энэхүү систем нь зорилгоо ханган ажиллаж байгаа ба Норвегийн фермерүүд нь энэхүү системийг ихээхэн дэмжиж, төрөл бүрийн салбарын борлуулалтын төвүүдэд харьяалагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Норвегид Засгийн газар нь хөдөө аж ахуйн салбарыг дэмжихэд цаг агаар, байгалийн таагүй нөхцөл ихээхэн нөлөөлсөн. Тус улсын цаг агаар болон газар нутгийн байршил нь хөдөө аж ахуйн үр ашигтай үйлдвэрлэл явуулахад тохиромжтой бус ба хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нь дэлхийн зах зээлтэй харьцуулахад харьцангуй өндөр өртөгтэй байдаг. Тиймээс Норвегийн хөдөө аж ахуйн салбарыг тогтвортой байлгах, тариаланчдыг орлогын эх үүсвэртэй байлгах үүднээс энэхүү зах зээлийг хамгаалалтад авах шаардлага үүсч байдаг. Тариаланчдын газар зүйн байршлыг зохицуулах зорилгоор ялгаатай тогтоосон татаас болон шилжүүлгүүдээс гадна фермерийн байгууллагууд ба Засгийн газрын хооронд хийгдэж буй жилийн хэлэлцээр нь тариаланчдын орлогын зорилтыг тодорхойлдог ба орлогын хуваарилалтыг зах зээл ба шууд шилжүүлэг гэсэн гол хоёр эх сурвалжид үндэслэн хуваарилдаг.[27]

ХБНГУ

1. Хөдөө аж ахуйн хоршооны туршлага, ерөнхий мэдээлэл

ХБНГУ дахь хоршоо /Deutsche Genossenschafts- und Raiffeisenverband e.V. (DGRV)/-д нь 150 гаруй жилийн түүхтэй бөгөөд тэдгээрийн үүсэл хөгжил нь Герман Шульце болон Фридрих Вилгельм фон Райффайзен нартай холбоотой юм. 1846 онд Ф.В.Райффайзен гишүүдийнхээ тэгш эрхийг хүндэтгэсэн, харилцан бие биедээ туслах зарчимд тулгуурласан “Ядуу фермерүүдийн өөртөө туслах холбоо” нэртэй хадгаламж зээлийн хоршоог үүсгэн байгуулснаар Германы хөдөө аж ахуйн салбарт томоохон эргэлт хийсэн гэж үздэг байна.

ХБНГУ-ын ХАА-н хоршоодын нэг онцлог нь тус салбарт 1889 оноос заавал аудит үйлчилж байгаа явдал юм. Анхан шат, муж болон холбооны 3 шатлал бүхий хоршоод нь 1930-аад он гэхэд бүрэлдэн тогтсон. Германы Райффайзены холбоо /DGRV/ нь ХАА-н хоршоодын хөгжилд голлох үүргийг гүйцэтгэсэн.

[27] УИХ-ын Тамгын газрын ПССХ, Хөдөө аж ахуйн салбарыг хоршооны зарчмаар хөгжүүлсэн зарим орны туршлага ба эрх зүйн орчин: Нэгдсэн борлуулалт, хангамжийн тогтолцоо, ХАА-н гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ бүрдэлт СТ-17/204

Түүнчлэн Европын Холбооны нэгдсэн зах зээл бий болсон нь германы үйлдвэрлэгч нарт борлуулалтын шинэ зах зээлд нэвтрэх боломжийг хөнгөвчилж, хөдөө аж ахуй болон хоршоодын хөгжилд таатай нөлөөлсөн гэж судлаачид дүгнэдэг.

Өнөөдрийн байдлаар тус улсад 2316 гаруй бараа, үйлчилгээ, ХАА-н хоршоод үйл ажиллагаа явуулж байна.[28] Германд үйлдвэрлэж буй бүхий л сүү, сүүн бүтээгдэхүүний 60%-ийн сүүний чиглэлийн хоршоод үйлдвэрлэдэг бол тариалсан нийт усан үзэмний гуравны нэгийг Усан үзэм тариалагчдын хоршоод хураан авч дарс үйлдвэрлэдэг байна. Үүнээс гадна Райффайзены хоршоод нь төрөл бүрийн үйлчилгээ, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрсний шинжилгээ хийх, малын тэжээл боловсруулалт болон боловсруулах үйлдвэрлэлийн шаардлагыг тогтоодог. Тус улсад хоршоод нийт 850 гаруй шатахуун түгээх станц ажиллуулдаг бөгөөд тэдгээр нь аж үйлдвэр, хөдөө аж ахуй болон хувь хэрэглэгч нарт үйлчилдэг байна. Үүнээс гадна 714 тусгай зах, 1500 гаруй Райффайзен дэлгүүр зэрэг ажилладаг байна. Дээрхээс гадна хоршоод боловсруулж болохуйц материал дахин боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна. Райффайзены байгууллагуудын бараа эргэлтийн хэмжээ 2014 оны жилийн эцсийн байдлаар 66 тэрбум евро байна.

Райффайзены хоршоод	**Хоршоодын тоо**	**Эргэлтийн хэмжээ, сая евро**
Бараа	424	37500
Сүүний хоршоод	225	14800
Мал аж ахуй, мах болон үржүүлгийн хоршоод	92	6600
Жимс, ногоо болон цэцэрлэгжүүлэлтийн хоршоод	88	3300
ХАА-н хоршоод	765	2000
Усан үзэм тариалагчдын хоршоо	169	800
Бусад	553	1000
Нийт	**2316**	**66000**

2. Хөдөө аж ахуйн хоршооны эрх зүйн орчин

ХБНГУ-д хоршоодын үйл ажиллагааг 1889 онд батлагдсан “Хоршооны тухай хууль”-иар зохицуулж байна. Хамгийн сүүлд тус хуульд 2006 онд Европын хоршоодтой холбоотой нэмэлт, өөрчлөлт орсон. Хоршоо нь хязгааргүй тооны гишүүн бүхий нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор үйл ажиллагаа явуулж буй нэгж, эсхүл гишүүд нь ашиг олох зорилгоор үйл ажиллагаагаа хамтран байгуулсан нэгжийг хэлнэ. Ийнхүү тус улс дахь хоршоодын эрх зүйн байдал нь хуулийн этгээдийнхтэй адил байна. Татварын хөнгөлөлт нь зөвхөн үйл ажиллагаагаа өөрсдийн гишүүдийн тусламжтай явуулж буй ХАА-н салбарт үйлчилнэ. ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуй, хэрэглэгчдийн эрх ашгийн хамгаалах яамаас гаргасан тоо мэдээнээс харахад ХАА-н аж үйлдвэр эзэмшигчдийн 51% нь хоршоод байна. Хуульд заасны дагуу хоршоо нь доод тал нь 3 гишүүнтэй байх бөгөөд үйл ажиллагааны улмаас бий болсон үүргийг зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцна.

[28] https://www.dgrv.de/en/cooperatives/$file/Facts_and_Figures.pdf

Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг нь хоршооны дүрэм байна. Хоршооны дүрэм болон тус хоршооны удирдлагын бүрэлдэхүүний талаарх мэдээллийг тухайн хоршоог харьяалах нутаг дэвсгэрийнхээ орон нутгийн шүүхэд бүртгүүлнэ.

Германы хоршоодын тухай хуульд дараахь асуудлыг тусгасан байна. Үүнд: Хоршооны эрх барих байгууллага нь дараахь 3 нэгжээс бүрдэх ба хоршооны удирдах дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал /Ерөнхий Ассамблей/, эсхүл Төлөөлөгчдийн Ерөнхий Ассамблей байна. Хяналтын зөвлөл нь доод тал нь 3, төлөөлөн удирдах зөвлөл нь доод тал нь 2 гишүүнтэй байна гэж заажээ. Мөн тус хуулиар хоршооны гишүүнчлэл, хоршооны эрх барих байгууллагуудын эрх, үүрэг, хоршоодын эд хөрөнгө хэрхэн бүрдэх, орлогын хуваарилалт, алдагдлыг нөхөх механизм, хоршоог татан буулгах, хөндлөн болон босоо интеграцчлал, маргаан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

3. Хөдөө аж ахуйн хоршооны борлуулалт, хангамж

Тус улсын ХАА-н хоршоодын эргэлт жилд 50 тэрбум евро байх ба үүнээс 50% нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, харин үлдсэн 50% нь шатахуун түгээх станц, барилгын материалын худалдаа болон хүнсний зах зээл эзэлж байна. Хоршоологчдыг Герман дахь болон олон улсын зах зээлтэй холбож буй гүүр нь хоршоологчдын холбоодын үүсгэн байгуулсан AGRAVIS Raiffeisen AG, Raiffeisen Waren GmbH, RWZ Rhein-Main eG, ZG Raiffeisen eG, BayWa Konzern зэрэг байгууллагууд юм.

ХАА-н хамгийн том концерн болох BayWa Konzern нь 1923 онд Мюнхенд байгуулагдсан бөгөөд 14.9 тэрбум еврогийн эргэлт, 16 мянга гаруй ажилтан, дэлхийн 34 оронд салбартай үйл ажиллагаа явуулж байна. Тус корпорац нь эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга болон үл хөдлөх хөрөнгийн салбарт голлон үйл ажиллагаа явуулдаг. ХАА-н салбарт холбооны гишүүддээ зориулан: мал аж ахуй болон газар тариалангийн түүхий эд, бараа бүтээгдэхүүний төлөвлөлт, тооцоо, агуулах, боловсруулалт болон борлуулалтаар хангаж, ХАА эрхлэгч, хэрэглэгч болон боловсруулах үйлдвэрүүдтэй холбох ажлыг гүйцэтгэх байна. Агуулах, тээвэрлэлтийн дэд бүтцээ өөрсдөө шийдвэрлэсэн нь улирлаас үл хамааран хэрэглэгчдэд бүтээгдэхүүн тасралтгүй нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Хоршоологчдын холбооны техник хангамж хариуцсан нэгж нь хөдөө аж ахуй эрхлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжаар хангахаас гадна техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцдаг. Борлуулалт, нийлүүлэлтийн үйлчилгээнээс гадна сургалт, зөвлөх үйлчилгээ болон санхүүжилтийг хариуцдаг. Хоршоологчдын холбоо нь хөдөө орон нутагт хүүхдийн ясли, цэцэрлэг, ахмад настныг асарч сувилах, ажиллах хүч бэлтгэх зэрэг нийгмийн асуудлуудыг мөн шийдвэрлэдэг.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Хөдөө аж ахуйн салбарыг хоршооны зарчмаар хөгжүүлсэн зарим орны туршлага ба эрх зүйн орчин: нэгдсэн борлуулалт, хангамжийн тогтолцоо, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ бүрдэлт 2017, Ц.Норовдондог, Д.Жигваагүнсэл Т.Саулегүл, Д.Халиун
- Хоршооны эрх зүйн зохицуулалт, гадаадын зарим орны туршлага 2012, Ц.Норовдондог, Г.Билгээ, Ц.Батдорж, Б.Дуламсүрэн, Ч.Онончимэг
- Японы Хөдөө аж ахуйн хоршоо https://life.ja-group.jp/message
- Хөдөө аж ахуйн хоршооны тухай хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=322AC0000000132_20230601_504AC0000000061
- Монополийн эсрэг хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=322AC0000000054
- Борлуулалт хангамж https://www.maff.go.jp/j/pr/aff/2203/spe1_01.html
- Amendments of the Agricultural Cooperative Act, Japan 2015, http://ap.fftc.agnet.org/ap_db.php?id=604
- Japanese agricultural cooperative development, Akio Yamamoto General Manager, JA-ZENCHU Central Union of Agricultural Cooperatives Tokyo, Japan http://www.fao.org/3/a-ae540e/ae540e06.htm
- The Agricultural Cooperative Society Law of Japan Law No. 132 of 1947 http://www.ilo.org/images/empent/static/coop/policy/pdf/japan.pdf
- The Japanese Agricultural Cooperative System: An Outline, Yoshihisa Godo, Meiji Gakuin University, Japan http://ap.fftc.agnet.org/ap_db.php?id=248&print=1
- National Federation of Agricultural Cooperative Associations, http://www.zennoh.or.jp/
- Empowering Japanese agriculture for global impact, McKinsey Japan October 2016, http://www.mckinsey.com/
- Treatment of Agricultural Cooperatives in the Antimonopoly Act in Japan, Yoshihisa Godo, 2015 http://ap.fftc.agnet.org/ap_db.php?id=547
- http://www.scandinavianlaw.se/pdf/45-7.pdf
- http://app.uio.no/ub/ujur/oversatte-lover/data/lov-20070629-081-eng.pdf
- http://www.lexadin.nl/wlg/legis/nofr/eur/lxwenoo.htm
- https://www.fearp.usp.br/cooperativismo/_up_arquivo/cooperative_identity_and_the_law.pdf
- http://ageconsearch.umn.edu/bitstream/24907/1/cp02te20.pdf
- http://images.library.wisc.edu/WI/EFacs/USAIN/CoopPrimer/reference/wi.coopprimer.i0010.pdf
- https://www.tine.no/english/about-tine/agricultural-cooperatives-in-norway
- http://www.med.gov.mn/mn/images/tailan/BS_13-04.pdf
- http://ageconsearch.umn.edu/bitstream/10129/1/46010040.pdf
- http://www.fao.org/docrep/007/ae540e/ae540e06.htm
- http://www.agnet.org/htmlarea_file/activities/20110719103351/paper-860033631.pdf- Agricultural Cooperatives in Korea
- https://www.oecd.org/tad/agricultural-policies/40383978.pdf-
- http://www.krei.re.kr/web/eng/oda;jsessionid=CCBBCCDEFFDBBDF5938BCF51EAB1A110?p_p_id=EXT_BBS&p_p_lifecycle=1&p_p_state=exclusive&p_p_mode=view&p_p_col_id=column-1&p_p_col_count=1&_EXT_BBS_struts_action=%2Fext%2Fbbs%2Fget_file&_EXT_BBS_extFileId=591-Development Experience of Agricultural Cooperatives in Korea
- http://www.jstor.org/stable/43109041?seq=1#page_scan_tab_contents- Cooperative Development in a Repressive Political System The Case of South Korea
- https://www.g-fras.org/fr/world-wide-extension-study/96-world-wide-extension-study/asia/eastern-asia/535-south-korea.html- South korea
- http://www.ilo.org/images/empent/static/coop/policy/pdf/japan.pdf

- http://jccu.coop/eng/public/pdf/asia_2012_07.pdf-

  https://www.dgrv.de/en/services.html
- Қазақстан Республикасының агроөнеркәсіптік кешенін дамыту жөніндегі 2021 – 2025 жылдарға арналған ұлттық жоба (Бүгд Найрамдах Казахстан Улсын хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн цогцолборыг 2021-2025 онуудад хөгжүүлэх үндэсний төсөл), https://primeminister.kz/assets/media/agronerksiptik-keshenin-damytu-zhnindegi-ltty-zhoba.pdf
- Қазақстан Республикасы Үкіметінің ресми ақпараттық ресурсы (Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газрын албан ёсны мэдээллийн хуудас), https://primeminister.kz/kz/news/reviews/auyl-sharuashylyg-y-onimderin-ondirushiler-ushin-u-synylatyn-zhan-a-mumkindikter-subsidiyalar-zh-ne-zhen-ildikti-nesieler-turleri-k-anday
- **О сельскохозяйственных кооперативах**, Закон Республики Казахстан от 29 октября 2015 года № 372-V ЗРК., https://adilet.zan.kz/rus/docs/Z1500000372
- Об утверждении типового устава сельскохозяйственного кооператива, Приказ Министра сельского хозяйства Республики Казахстан от 24 декабря 2015 года № 1-2/1117., https://adilet.zan.kz/kaz/docs/V1500012685
- Об утверждении Концепции развития агропромышленного комплекса Республики Казахстан на 2021 – 2030 годы,Постановление Правительства Республики Казахстан от 30 декабря 2021 года № 960., https://adilet.zan.kz/rus/docs/P2100000960#z263
- Государственная программа развития агропромышленного комплекса Республики Казахстан на 2017-2021 годы, Постановление Правительства Республики Казахстан от 12 июля 2018 года № 423., https://adilet.zan.kz/rus/docs/P1800000423
- Мониторинг развития сельскохозяйственной кооперации в Казахстане, OECD, https://www.oecd.org/eurasia/competitiveness-programme/central-asia/Kazakhstan-Monitoring-Agricultural-Co-operatives-2019-RUS.pdf